



ЖИЛИЙН ТАЙЛАН 2023



2023 ОНЫ ТОЙМ

Бид тулгарсан бүхий л сорилтыг давж, 2023 оноо амжилт бүтээлээр дүүрэн үдлээ. 2023 оны гуравдугаар сард гүний уурхайн олборлолт эхэлсэн нь ил болон гүний уурхай бүхий зэсийн цогт бизнес болоход нэн ач холбогдолтой үйл явдал байлаа. Энэ амжилтад хүрэхэд олон

арван жилийн хүч хөдөлмөрөө зориулж, хувь нэмэр оруулсан хүн бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Гүний уурхайн бүтээн байгуулалт төлөвлөсөн хугацаандаа амжилттай хэрэгжиж, Оюу толгойн уурхайн олборлолтыг бүрэн хүчин чадалд нь хүргэхэд алхам алхмаар ойртсоор байна. Одоогоор “Панель 0”-т 86 хүдэр буулгуурын тэсэлгээг амжилттэй гүйцэтгэсэнээр тус олборлолтын хэсэгт хийх ажлын гүйцэтгэл 70 хувьд хүрэв. 2023 онд нийт хүдрийн 9 хувийг гүний уурхайгаас олборлосон бол энэ үзүүлэлтийг 2024 онд 17 хувьд хүргэх зорилготой байгаа билээ.

Гүний болон ил уурхайн гүйцэтгэл өндөр байснаар бид бизнесийн зорилтуудаа давуулан биелүүлсэн юм. 2023 онд Оюу толгойн баяжуулах үйлдвэр 39.3 сая тонн хүдэр боловсруулж 39,1 сая тонн хүдэр боловсруулах төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн бөгөөд нийт 795.7 мянган тонн баяжмал үйлдвэрлэсэн. Нийт үйлдвэрлэсэн зэс (төлөвлөсөн: 160 мянган тонн, гүйцэтгэл: 168 мянган тонн) болон алт (төлөвлөсөн: 154 мянган унц, гүйцэтгэл: 177 мянган унц)-ны хэмжээгээр төлөвлөгөөгөө мөн давууллаа.

Өнгөрөгч онд борлуулалтын нийт орлого 1.6 тэрбум ам.долларт хүрсэн нь төлөвлөснөөс 18 хувь давсан үзүүлэлт юм. Борлуулалт ийнхүү нэмэгдсэн нь дэлхийн зах зээл дээрх зэс болон алтны үнэ өссөн, баяжмалын борлуулалт 2023 онд нэмэгдсэнээс голчлон шалтгаалжээ.

Үүнээс дутахааргүй том амжилт бол бид аюулгүй ажиллагааны өндөр гүйцэтгэлээ хадгалж чадсан явдал. Бид аюулгүй ажиллагааг үйл ажиллагааныхаа хүрээнд улам сайжруулсаар байгаа бөгөөд ирээдүйд ч энэ үзүүлэлтээ тогтвортой хадгалах тодорхой төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж буй. Бид 2023 оныг хүний амь нас эрсэдсэн осолгүй, Гэмтэл бэртлийн давтамжийн 0.20



Гүний болон ил уурхайн гүйцэтгэл өндөр байснаар бид бизнесийн зорилтуудаа давуулан биелүүллээ.



Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Рио Тинтогийн Гүйцэтгэх захирал Якоб Стаусхолмын хамт гүний уурхайн олборлолтыг эхлүүллээ. 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдөр

үзүүлэлттэй үдэв. Түүнчлэн, ажлын байрны хүртээмж, олон талт, ялгаатай болон эрх тэгш байдлыг нэмэгдүүлэхэд ахиц гарлаа. 2023 оны байдлаар нийт ажиллах хүчний 23 хувь нь эмэгтэй ажилчид бий.

Хэдийгээр ололт, амжилтаар арвин жил өнгөрч буй ч цаашид хүрэх зорилт, бүтээх ажил цөөнгүй байна. Бид 2023 онд ажилтан бүрд илүү ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлж, хүйс, яс үндэс, шашин шүтлэгээсээ үл хамааран бүгд эрх тэгш харилцдаг байх соёлыг төлөвшүүлэхийн төлөө олон шинэ төсөл, санаачилга хэрэгжүүлж эхэлсэн. Түүнчлэн нийт ажиллах хүчний дотоод, гадаад ажилчдын харьцааг 90:10-д хадгалах амлалтаа давуулан биелүүлсэн бөгөөд одоогоор нийт ажилчдын 97.2 хувь нь монголчууд байна. Ажилчдынхаа хувийн болон мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд нийт 800 мянга гаруй хүн цагийн сургалтыг зохион байгуулсан нь бас нэгэн том амжилт.

“Оюу толгой”-н хамт олон ажиллах орчноо сайжруулах, хамт олноо чадваржуулахын төлөө тууштай

“

“Монгол Улс дэлхийн тэргүүлэх зэс үйлдвэрлэгч болоход чухал ач холбогдол бүхий энэ том амжилтыг Рио Тинтотой хамт тэмдэглэж байгаадаа баяртай байна.”

Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ

“

“Говь нутагт газрын гадаргаас 1,300 метрийн дор орших гүний уурхайн олборлолтыг ийнхүү хамтдаа эхлүүлж байна. Дэлхийн энтэй, өндөр технологиор тоноглогдсон энэ уурхайн үйлдвэрлэх зэс хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад шаардлагатай цахилгаанжуулалтын үйл хэрэг болон Рио Тинтогийн зэсийн бизнес тэлэхэд хувь нэмрээ оруулна.”

“Рио Тинто” компанийн Гүйцэтгэх захирал Якоб Стаусхолм



ажиллаж буйг үнэлэн, “Mongolian Talent Network” компаниас биднийг “Ажиллахад хамгийн таатай компани”-иар шалгаруулсан билээ.

Орон нутгийн иргэд, оролцогч талуудтай хамтын ажиллагаагаа улам бэхжүүлэх нь бидний хөгжил цэцэглэлтэд хамтдаа хүрэх зорилгын салшгүй нэг хэсэг. Өнгөрсөн онд бид “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” болон “Ханбогдын хөгжлийн хурдасгуур сан”-гийн хүрээнд нийт 80 төсөл, хөтөлбөрийг 28.5 тэрбум төгрөгөөр (8.2 сая ам.доллар) санхүүжүүллээ.

2023 он Ханбогд сумын урт хугацааны тогтвортой хөгжлийг бататгахад чиглэсэн “Ханбогдын хөгжлийн хурдасгуур сан”-гаар дамжин хэрэгжих 5 жилийн төлөвлөгөө гараанаас гарч, төсөл хөтөлбөрийн санхүүжилт олгогдож эхэлсэн чухал жил байв. Энэ хүрээнд тус сумын төвийг эрүүл, аюулгүй, иргэдэд ээлтэй хот болгоход чухал ач холбогдол бүхий хэд хэдэн төсөл хэрэгжиж эхэллээ.

Хүрээлэн буй байгаль орчноо хамгаалах, унаган төрөхөөр нь хадгалан үлдээх амлалт бидний хувьд мөн эрхэм чухал. Бид 2023 онд өмнөх жилүүдийн адилаар усны хэрэглээгээ боломжит доод түвшинд барьж, ус дахин ашиглахад гойд анхаарч ажиллалаа.

Оюу толгой 2023 оны байдлаар хэрэглэсэн усныхаа 85.7 хувийг дахин ашиглаж, нэг тонн хүдэр боловсруулахад 0.39 шоо метр ус ашиглаж буй нь дэлхийн дундаж болох 1.2 шоо метрээс мэдэгдэхүйц дээгүүр үзүүлэлт юм. 2023 онд бид дотоодын хог дахин боловсруулах 17 компанитай хамтарсан. Манай нийт хог хаягдлын 61 хувийг дахин боловсруулагдах хог хаягдал эзэлж байна.

“Оюу толгой” компани Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт байх Ялбаг голын хөндийд хариуцлагагүй бичил уул уурхайн улмаас эвдэрч, сүйдсэн 400.4 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэсэн. Мөн 2023 онд 45.45 га газарт биологийн нөхөн сэргээлт, өмнө биологийн нөхөн сэргээлт хийгдсэн 51.76 га газарт нэмэлт сайжруулалт, Гашуунсухайт чиглэлийн авто зам болон Гүний хоолой орчмын 64.34 га газарт техникийн нөхөн сэргээлт хийв.

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжих чиглэлээр Ханбогд сумд жилд 250 мянга, Цогт-Овоо сумд жилд 500 мянган тарьц, суулгац ургуулах хүчин чадалтай мод үржүүлгийн хоёр газрыг шинээр байгууллаа. Үүнээс гадна нийт 58,503 модны үрсэлгээг “Оюу толгой” болон хамтрагч байгууллагын 3,067 ажилчдад түгээсэн.



ОНЫ ТОЙМ

2023



БЭЛЭН Бай

Гуравдугаар сарын 17

ОБЕГ-тай хамтран газар хөдлөлтийн эрсдэлээс сэргийлэх "Бэлэн бай" үндэсний аянг эхлүүлээ.

Зургаадугаар сарын 20

Оюу толгойн шинэчлэгдсэн стратегийг Төлөөлөн удирдах зөвлөл батлав.

Хоёрдугаар сарын 19

ШУТИС-д бүрэн тоногдсон геотехникийн лаборатори хүлээлгэн өгөв.

Тавдугаар сарын 18

"Оюу толгой" ХХК МҮХАҮТ-аас шалгаруулдаг "Шилдэг зуун аж ахуй нэгж"-ийн тэргүүн байрт анх удаа шалгарав.

Гуравдугаар сарын 15

Оюу толгойн баяжуулах үйлдвэрийн 10 жилийн ой тохиов.

Гуравдугаар сарын 13

Гүний уурхайн олборлолт эхэлснээр Оюу толгой зэсийн цогц уурхай боллоо.

Хоёрдугаар сарын 10

Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай "Зуун сая мод" хөтөлбөрийг хэрэгжүүлэх Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав.



Долоодугаар сарын 9-14

"Рио Тинто" компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын баг Монголын эдийн засгийн форумд оролцлоо.

Аравдугаар сарын 5

"Оюу толгой" ХХК боловсролын салбарын Шилдэг хөрөнгө оруулагчаар шалгарлаа.

Арван нэгдүгээр сарын 24

Хариуцлагагүй уул уурхайн улмаас сүйдсэн 187 га газрыг нөхөн сэргээх харилцан ойлголцлын санамж бичиг Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай байгуулав.



Аравдугаар сарын 21

ОБЕГ-тай "Гамшгийн эрсдэлийг бууруулах, чадавхжуулах" харилцан ойлголцлын санамж бичиг байгуулав.

Арван нэгдүгээр сарын 24

Оюу толгойн Байгаль орчны баг байгуулагдсаны 20 жилийн ой тохиов.

Долоодугаар сарын 27

Ажилчдын урт хугацааны санхүүгийн тогтвортой байдлыг хангах "Тэтгэвэр хуримтлалын сан" хэрэгжиж эхэллээ.

Долоодугаар сарын 9-13

"Оюу толгой" төслийн санхүүжүүлэгч байгууллагуудын төлөөлөл Монгол Улсад ажиллав.



Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ

Оюутолгойчууд 2023 онд дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхийн төлөө нар, сартай уралдан зүтгэсний дүнд үйл ажиллагаагаа аюул осолгүй, жигд үргэлжлүүлэхийн сацуу гүний уурхайнхаа олборлолтыг эхлүүлснийг бахархан мэндчилж байна.

Төр засгийн төв болоод орон нутгийн байгууллагуудын халуун дэмжлэг, тус компанийн хөдөлмөрч хамт олон, гэрээт компаниуд, хамтран ажиллагч талуудын олон жилийн хамтын чармайлтын хүчинд дээрх амжилтад хүрснийг цохон тэмдэглэе. Манай орны уул уурхайн салбарын шинэ зууны түүхийн хуудаснаа тод бичигдэх энэхүү амжилтад үнэтэй хувь нэмэр оруулсан хүн тус бүрд халуун баяр хүргэх ялдамд чин сэтгэлийн талархал дэвшүүлье.

Өнгөрсөн оны 6 дугаар сард Төлөөлөн удирдах зөвлөлөөс тус компанийн бизнесийн хөгжлийн урт хугацааны стратегийг шинэчлэн баталлаа. Эртний түүхт Хархорумд хуралдаж баталсан уг баримт бичигт ойрын жилүүд, дунд хугацааны болоод хэтийн хөгжлийн стратегийн тэргүүлэх гол зорилт, үндсэн чиглэлүүдээ тусгасан юм. Эдгээрт ажилчдын ур чадавхыг улам бэхжүүлэх, тэдний өсөн дэвжих боломж, амьдралын болон ажлын бүх талын таатай нөхцөлийг бүрдүүлэх, орон нутаг хийгээд улс орны хөгжил дэвшлийн төлөө хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, байгаль орчноо хайрлан хамгаалах үйлсэд оруулж буй хувь нэмрээ нэмэгдүүлэх, үйл ажиллагааны үр өгөөжийг тогтвортой өсгөх зэрэг чухал зорилт тавигдсан болно.



“Рио Тинто” компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагын баг, мөн хөрөнгө оруулагчид, олон улсын санхүүгийн байгууллагууд хийгээд түнш компаниудын төлөөлөл манай уурхайн цогцолборт зочилж танилцсан онцлог жил болсныг дурдъя. Галбын говьд монгол хүмүүний болон гадаад мэргэжилтэн нарын ур ухаан, хүч хөдөлмөрөөр сүндэрлэсэн аварга бүтээн байгуулалттай танилцан баяр хүргэсэн нь оюутолгойчуудын урам зоригийг улам их бадраасан юм.

“Оюу толгой” компанийн нийт хамт олны нэрийн өмнөөс хувь нийлүүлэгчид, Говь нутгийн зон олон болон түншлэгч байгууллагуудад гүн талархах ялдамд цаашдын хамтын амжилт, хамтын үр өгөөжийн төлөө хамтран зүтгэхийг чин сэтгэлээсээ эрмэлзэж буйгаа илэрхийлье.

Эцэст нь, мятаршгүй бүтээлч бөгөөд цуцалтгүй хөдөлмөрч нийт оюутолгойчууд, мөн тэднийхээ гэр бүлд эрүүл энхийн түмэн жаргаланг ерөөе.

Элчин сайд Галсангийн Батсүх



Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Дэйдрэ Лингенфэлдер

“2023 онд Оюу толгой зэсийн цогц бизнес болсон нь түүхэн үйл явдал байлаа.”

Оюу толгойн хувьд 2023 он онцгой жил байлаа. Гуравдугаар сард гүний уурхайн олборлолт эхэлсэн нь бидний хувьд мартагдашгүй чухал үйл явдал болсон. Энэ нь Оюу толгойг гадаргын уурхайн төслөөс зэсийн цогц бизнес болгож буй чухал алхам юм. Энэхүү амжилт нь манай хувь нийлүүлэгчдийн олон жилийн хүчин зүтгэл, оролцогч талууд, ханган нийлүүлэгчдийн хамтын ажиллагааны тууштай дэмжлэг, мөн манай үйл ажиллагааны ноён нуруу болсон чадварлаг хамт олны маань шаргуу хөдөлмөрийн үр дүн билээ. Гайхалтай амжилтын эзэд болсон нийт баг хамт олондоо Гүйцэтгэх удирдлагын багийн нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн талархал илэрхийлье. Эдүгээ бид гүний уурхайн үйл ажиллагааг аюулгүй, тогтвортой эрчимжүүлэхэд анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Онцолбол зохих өөр нэг үйл явдал бол манай урт хугацааны "Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе" стратеги батлагдаж, хэрэгжиж эхэлсэн явдал юм. Энэхүү шинэчилсэн стратеги нь орон нутаг, говийн бүс, цаашилбал Монгол Улсад илүү их үнэ цэн, эерэг нөлөө, хөгжил цэцэглэлтийг авчрах зорилго бүхий, бидний хүсэл эрмэлзэл, урт хугацааны зорилтуудыг тусгасан баримт бичиг юм. Манай стратеги хамт олон, хамтын ажиллагаа, хөрст дэлхий, хүртэх өгөөж гэх дөрвөн тэргүүлэх чиглэлээс бүрдэж буй. Энэхүү стратеги нь манай хүсэл эрмэлзэл, зорилго, зорилтыг адил тэгш эрхэмлэх үндэс суурийг бүрдүүлэх юм.

2023 онд бид гүний уурхайн олборлолтыг эрчимжүүлэхийн сацуу аюулгүй ажиллагааны үзүүлэлтээ өндөр түвшинд хадгаллаа. Улмаар байгууллагынхаа ажиллах орчныг хүн нэг бүрийн хүйс, яс үндэс, шашин шүтлэгийг хүндэтгэсэн, илүү ээлтэй, аюулгүй орчин болгоход чухал ахиц гаргасан. Гэвч бидэнд цаашид хийж, хэрэгжүүлэх олон ажил бий. “Оюу толгой”-н тэтгэлэгт болон дадлагажуулах хөтөлбөр тэргүүтэй санаачилгууд нь монгол залууст ирээдүйгээ бүтээж, хүсэл мөрөөдлөөрөө жигүүрлэн гайхалтай амжилтад хүрэхэд нь дэмжлэг болно гэдэгт итгэж байна. Хамтын ажиллагааны хүрээнд бид өнгөрсөн жил үндэсний болон орон нутгийн ТББ-уудтай хамтран ажиллаж, илүү эерэг үр дүнд хүрч чадлаа.

“Гэрэлт” төсөл бол энэ хүрээнд бидний хийж хэрэгжүүлж буй бахархам төслийн нэг. 2020 оноос хойш бид хэд хэдэн ТББ-тай хамтран уг төслийг хэрэгжүүлж, Улаанбаатар хотын гэр хорооллын сургуулиудын өсвөр үеийнхний сэтгэл зүй, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих чиглэлд хувь нэмрээ оруулж ирлээ. Төслийн хүрээнд 13 сургуульд сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, сургалтын танхим бүрэн тохижуулж, 33 мянган хүнд сэтгэл зүйн зөвлөгөө хүргэсэн юм. 2023 онд бид төслийнхөө цар хүрээг тэлж, нэмж дөрвөн сургуульд хэрэгжүүлж эхлээд байна.

Хүрээлэн буй орчноо хайрлан, хамгаалах нь Оюу толгойн тэргүүлэх чиглэл байсаар ирсэн. Бид эх дэлхийгээ онгон

дагшин хэвээр хадгалах, байгаль орчноо хамгаалахын чухлыг ухамсарлаж, үйл ажиллагаа явуулж буй нутагтаа үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад тэргүүн зэргийн анхаарал, ач холбогдол өгдөг. Өнгөрсөн онд бид ус дахин ашиглалтын жишиг үзүүлэлтээ хадгаллаа. Цаашилбал, хог хаягдлын менежмент, биологийн олон төрөл зүйлийн байдлыг хадгалах чиглэлээр мэдэгдэхүйц ахиц дэвшил гаргасаар байна. Мөн өнгөрсөн онд Сэлэнгэ аймгийн Ялбагийн хөндий дэх эвдрэлд орж, сүйдсэн 400 гаруй га талбайд техникийн нөхөн сэргээлт хийлээ.

Энэ жил Дархан-Уул аймгийн Шарын гол орчмын хууль бус олборлолтын улмаас эвдэрсэн 187 га газрыг нөхөн сэргээж, байгаль орчноо хамгаалах үйл хэргээ үргэлжлүүлнэ. Тулгамдаж буй саад бэрхшээлийг даван туулахад илүү хүчин чармайлт гаргах хүлээлт, шаардлага байгааг бид ухамсарлаж буй. Итгэлцэлд суурилсан илэн далангүй түншлэл цогцлоох нь бидний үйл ажиллагааны үндсэн зарчим билээ.

Бид хаягдал хадгалах байгууламжийн шүүрлийг илрүүлснээс хойш ил тод, нээлттэй хэлэлцэж, холбогдох оролцогч талуудтай тогтмол харилцан ажиллаж, болзошгүй сөрөг үр дагаврыг багасгахын тулд Шүүрлийг бууруулах цогц арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.

Бизнесийн үйл ажиллагаа ашигтай байх нь үүрэг, амлалтаа биелүүлэх үндэс суурь болно. 2023 онд бид уурхайн болон санхүүгийн төлөвлөгөөгөө давуулан биелүүллээ. Манай амжилтад хэд хэдэн хүчин зүйл нөлөөлсөн. Тухайлбал, гүний уурхайн хүдрийн хэмжээ нэмэгдэж, агуулга хийгээд металл олборлолтын түвшин өндөр байсан нь зэсийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн.

Үүний үр дүнд бид зэсийн борлуулалтыг төлөвлөгөөнөөс 9 хувиар давсан амжилтаар 2023 оноо үдлээ. 2028-2036 оны хооронд жилд үйлдвэрлэх зэсийн үйлдвэрлэлийг ойролцоогоор 500 мянган тонн хүртэл нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байгаа энэ үед 2023 оны үйл ажиллагааны өндөр гүйцэтгэл нь бидэнд ихээхэн урам зориг өгч байна.

Цаашид бид төлөвлөгөөгөө биелүүлж, хувь эзэмшигч, хамтрагч, оролцогч талын хүлээлтийг биелүүлэхийн төлөө хичээнгүйлэн ажиллах болно.

Та бүхний дэмжлэгт баярлалаа.

Гүйцэтгэх захирал
Дэйрдэр Лингенфэлдер





Гүйцэтгэх удирдлагын баг

**ДЭЙРДРЭ
ЛИНГЕНФЭЛДЕР**
Гүйцэтгэх захирал



ЖАК ВАН ТОНДЕР
Гүний уурхайн болон
Хөгжлийн төслүүд
хариуцсан захирал (-2023)



ЭНДРЬЮ ЛАЯ
Уурхайн үйл ажиллагаа
эрхэлсэн захирал (2024-)



МЕЛИССА ШАНЕНГАНГЕ
Боловсон хүчин, бүтэц
зохион байгуулалт
хариуцсан Ерөнхий
менежер



РОЖЕР МКНЕЙЛ
Худалдан авалтын
газрын Ерөнхий
менежер (-2023)



ХИКМЕТ ГАИБОВ
Худалдан авалтын
газрын Ерөнхий
менежер (2024-)



КЛЭЙР ЭЛАЙДЕН
Стратеги, бизнес
нэгтгэлийн Ерөнхий
менежер

**БЭГЗЖАВЫН
ДУЛАМСҮРЭН**
Санхүү эрхэлсэн
захирал



**ЦЭРЭВСҮРЭНГИЙН
ЦЭРЭНХҮҮ**
Компанийн нарийн
бичгийн дарга бөгөөд
хэрэг эрхлэх газрын дарга



ЭНДРЬО ВИЛСОН
Уурхайн үйл ажиллагаа
эрхэлсэн захирал
(-2024)



**ДАШНЯМЫН
АМАРБАЯСГАЛАН**
Хууль, эрх зүйн асуудал
хариуцсан захирал



ДАМИАН РОЖЕРС
Гүний уурхайн төслийн
захирал



ЭРДЭНИЙН ЛХАГВА
Хамтын ажиллагаа,
мэдээлэл харилцааны
газрын Ерөнхий
менежер



ФИЛИП АБРАХАМ
Эрүүл мэнд, аюулгүй
ажиллагаа, байгаль
орчин, аюулгүй байдал
(ЭМААБОАБ) хариуцсан
Ерөнхий менежер



**ПҮРЭВСҮРЭНГИЙН
БАЙГАЛМАА**
Бизнес хөгжүүлэлт,
бизнес сайжруулалт
хариуцсан Ахлах
менежер (2024-)

Манай бизнес

Улаанбаатар

Даланзадгад

Ханбогд

Оюу толгой

Гашуун сухайт

Говьд сүндэрлэсэн дэлхийн энтэй уурхай

Оюу толгой нь Монгол Улсын Өмнөговь аймагт орших дэлхийн хэмжээний томоохон уурхай бөгөөд зэсийн агуулгаараа дэлхийд тэргүүлдэг ордын нэг юм. Тус ордыг анх 2001 онд нээн илрүүлсэн түүхтэй.

“Оюу толгой” ХХК нь “Рио Тинто” групп (66 хувь) болон “Эрдэнэс Оюу толгой” ХХК (34 хувь)-ийн хувь нийлүүлсэн компани юм. Хувь нийлүүлэгч “Эрдэнэс Оюу толгой” ХХК нь Монгол Улсын төрийн өмчит компани. “Рио Тинто” 2010 оноос хойш Оюу толгойн стратеги болон үйл ажиллагааны менежментийг хэрэгжүүлж байна.

“Оюу толгой” уурхайн цогцолбор Улаанбаатар хотоос өмнө зүгт 550 километр, Монгол-Хятадын хилээс хойд зүгт 80 орчим километрт оршдог.

2024 онд
зэсийн
олборлолт

40%


НЭМЭГДЭНЭ

2024 онд гүний
уурхайгаас
зөөвөрлөх
нийт
чулуулгийн
хэмжээ


2X

ӨСНӨ.

Зэсийн олборлолтын
төсөөлөл
(мянган тонн)



2028-2036 онд жилд үйлдвэрлэх
зэсийн хэмжээ 3 дахин нэмэгдэнэ.



Нийт ажилчдын

23.3%

нь эмэгтэй.

Цаашид нийт ажиллах хүчний 50 хувийг эмэгтэйчүүдээс бүрдүүлэхээр төлөвлөж байна.

Нийт худалдан авалтын

89.2%

дотооддоо зарцуулсан

Нийгмийн сайн сайхны төлөө

27 сая

ам.доллар зарцуулав

Сүүлийн арван жилд осол, гэмтэл

50%

буурав.




Уул уурхайн бизнесийн бүхий л чиглэлээр мэргэшсэн гүйцэтгэх удирдлагын баг “Оюу толгой” ХХК-ийг удирдан, стратегийн бодлогыг нь хэрэгжүүлдэг. “Оюу толгой” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувь нийлүүлэгч талуудын төлөөллөөс бүрддэг бөгөөд компанийн стратегийн чиглэлийн дагуу шийдвэр гаргах, хяналт тавих үүрэг гүйцэтгэдэг юм.

2023 оны эцсийн байдлаар “Оюу толгой”-н нийт ажиллах хүчний 97 хувь нь монголчууд бөгөөд тэдний 23 хувийг Өмнөговь аймгийн иргэд бүрдүүлж байна. Манай хамт олон “Бидний ажлын арга барил” хэмээх ёс зүйн дүрмийг бизнесийн аливаа шийдвэр гаргахаас гадна өдөр тутмын ажлаа гүйцэтгэхдээ мөрдлөг болгон ажилладаг. Энэхүү ёс зүйн дүрэмд байгаль орчны хамгаалал, тогтвортой хөгжлийг цогцлоох, авлигаас ангид байх зарчим, ажилчдын ёс зүй, эрх үүргийн ойлголтууд тусгагдсан болно.

Оюу толгойн уурхай нь ил болон гүний уурхайгаас бүрдэх бөгөөд гүний уурхайн олборлолт 2023 оны гуравдугаар сард эхэлсэн билээ. Уурхай ашиглалтын хувьд ил уурхайгаас хүдэр олборлож, хоногт 100,000 тонн хүдэр баяжуулах хүчин чадал бүхий баяжуулах үйлдвэр, дагалдах байгууламж, дэд бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэх үед Оюу толгой нь бага зардлаар үйлдвэрлэл явуулдаг дэлхийд өрсөлдөхүйц томоохон зэсийн уурхайн нэг болох юм.

Гэмтэл бэртлийн давтамжийн үзүүлэлт


(200,000 хүн/цагт ногдох)



2023 оны эцсийн байдлаар Оюу толгойн 200,000 хүн/цагт ногдох Бүх гэмтэл, бэртлийн давтамжийн үзүүлэлт 0.20 байсан нь "Рио Тинто" группийн хэмжээнд хамгийн аюулгүй уурхайн нэг болохыг батлан харууллаа.

Баяжмал үйлдвэрлэл

(мян.тонн, хуурай жингээр)



2023 онд нийт 795.7 мянган тонн баяжмал үйлдвэрлэв.

Баяжмалын борлуулалт

(мян.тонн, хуурай жингээр)

823

823 металлын агууламжтай 166 мянган тонн (kt) зэс (2022: 132kt); 175 мянган унц (koz) алт (2022: 207koz); болон 1,008 мянган унц (koz) мөнгө (2022: 836koz) баяжмал борлуулав.

Гадаргын урсгал капиталын зардал

(сая ам.доллар)

150


Гадаргын урсгал капиталын зардал 2022 онд 152 сая ам.доллар байснаас бага зэрэг буурав.

ОНЫ ТОВЧООН

2023 оны үйл ажиллагааны тойм

Бид хэдийгээр үйл ажиллагаа, ханган нийлүүлэлт, тоног төхөөрөмжийн хүртээмжтэй холбоотой олон саад бэрхшээлтэй тулгарсан ч 2023 оныг амжилт бүтээлээр дүүрэн үдэж байна.

Гүний уурхайн олборлолт эхэлсэн нь зэсийн цогц бизнес болоход чухал алхам байлаа. 2023 оны үйлдвэрлэлийн болон борлуулалтын зорилтоо давуулан биелүүлсэн нь биднийг 2024 онд улам амжилттай ажиллахад түлхэц болно.



4545

"Оюу толгой" ХХК-ийн нийт ажиллах хүч



23.3%


эмэгтэй уурхайчин

Хүйсийн тэгш байдлын хувьд Оюу толгой дэлхийн дундаж болох 15 хувиас харьцангуй өндөр байна.


Дотоодод зарцуулсан нийт мөнгөн хөрөнгө

(2010 - 2023)

16.8 тэрбум ам.доллар



2010 оноос хойш үндэсний компаниудтай хийсэн худалдан авалт, төсөвт төлж буй татвар, хураамж, үндсэн ажилчдын цалинд нийт 16.8 тэрбум ам.доллар зарцууллаа.



“100 сая мод” хөтөлбөр

Жилд Ханбогд сумд 250,000, Цогт-Овоо сумд 500,000 тарьц, суулгац ургуулах хүчин чадалтай мод үржүүлгийн хоёр газар байгуулсан.

Богд уулын Түргэний аманд түймэрт өртсөн 70 га талбайг хашаажуулж, 38 га талбайд ойжуулалтын ажил гүйцэтгэв.

Сэлэнгэ аймгийн Ялбагийн хөндий дэх, хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр хөндөгдөж, орхигдсон 400.4 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Нийт 58,503 мод, тарьц, суулгацыг 3,067 ажилтанд тараасан.

Ханбогд сумын угтах хаалганы ойн зурвас 17 га талбайд 15,000 мод тарьсан.

Дотоодын худалдан авалт

Өсөн нэмэгдсэн дүнгээр

11.2 тэрбум ам.доллар

2023 онд үйл ажиллагааны худалдан авалтын баг 969 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 700 нь үндэсний компани байв. Эдгээр үндэсний компанид худалдан авалтынхаа 89 хувийг зарцуулав. 2010 оноос хойш үндэсний худалдан авалтад 11.2 тэрбум ам.доллар зарцуулсан.

969

2023 онд нийт 969 ханган нийлүүлэгч

Өмнөговь аймгийн хэмжээнд хийсэн худалдан авалт

(сая ам.доллар)


2010-2023

1,421 / 272
2023

2023 онд Өмнөговь аймагт бүртгэлтэй 104 ханган нийлүүлэгч 272.4 сая ам.долларын бараа, үйлчилгээ хүргэв. 2010 оноос хойш Өмнөговь аймгаас нийт 1.421 тэрбум ам.долларын бараа, үйлчилгээг "Оюу толгой" ХХК худалдан авчээ.

Татвар, хураамж болон бусад төлбөр


(2010 - 2023 он, сая ам.доллар)



2010 оноос хойш татвар, хураамж, үндэсний компаниудад төлсөн НӨАТ зэрэг бусад төлбөрт 4.3 тэрбум ам.доллар төлсөн. 2023 онд татвар, хураамж бусад төлбөрт 408 сая ам.доллар төлжээ.

* "Оюу толгой" ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.
** Энэ дүнд олон улсын арбитраг хэлэлцэж буй 356 сая ам.долларын төлбөр багтсан болно.

УС ДАХИН АШИГЛАЛТЫН ХУВЬ (%)



85.7%

2023 оны эцсийн байдлаар ус дахин ашиглалтын зорилт болох 80 хувиа давуулан 85.7 хувьд хүргэлээ.

УС АШИГЛАЛТЫН ТӨЛБӨР (2013 - 2023)

2023 онд ус ашиглалтын төлбөрт нийт 66 сая ам.доллар төлжээ.

66 сая ам.доллар

Шинэчлэгдсэн стратеги

Дэлхий ертөнц өдгөө хурдацтай өөрчлөгдөж байна. Шинээр гарч ирж буй технологиуд цаг цагаар хөгжин нэмэлт боломжуудыг нээж, хэдхэн жилийн өмнө бүтэшгүйд тооцогдож байсан санаа эдүгээ биэллээ олох нөхцөл үүссэн төдийгүй түүнээс ч илүүг бүтээх боломж бүрджээ. Түүнчлэн, уур амьсгалын өөрчлөлт тэргүүтэй сорилтууд биднийг ажиллах арга барилаа эргэн харж, шаардлагатай сайжруулалтыг хийхийг шаардаж буй. Уул уурхай энэ өөрчлөлтийн урсгалаар л яваад өнгөрөлгүй, асуудлын шийдлийг олохоор түүчээлж байна. Ирээдүйд технологийн хөгжлийн гол хөдөлгүүр нь зэс болж, дэлхий ертөнцийн ирээдүйн сайн сайхан байдалд чухал нөлөө үзүүлэх нь дамжиггүй. Байгаль орчинд илүү ээлтэй эрчим хүчний үйлдвэрлэл нэмэгдсэнээр 2035 он гэхэд дэлхийн зэсийн эрэлт хоёр дахин нэмэгдэх төлөвтэй байгаа бөгөөд одоогийн тооцооллоор зэсийн хэрэгцээг хангаж дийлэхээргүй байна.

Оюу толгойн дэлхийд өрсөлдөх давуу талууд болох авьяаслаг, ур чадвартай, хөдөлмөрч хамт олон, хүдрийн гайхалтай нөөц, болон олон жилийн туршид бий болгосон хамтын ажиллагаа нь биднийг зөвхөн Монгол Улсын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулаад зогсохгүй даян дэлхийн сайн сайхан байдлыг

Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе.

бүтээлцэхэд туслах юм.

Оюу толгой эдүгээ түүхийнхээ нэгэн шинэ хуудсыг эхлүүлж байна. Гүний уурхайн олборлолт эхэлснээр бид ирээдүйд улам өсөн дэвжих замаа заслаа. Гэвч эерэг үр нөлөөг үргэлжлүүлж, өнөөгийн болон ирээдүйн эрсдэлийг давж гарахад бидэнд урт хугацааны төлөвлөгөө чухал. Иймд "Оюу толгой" компанийн Төлөөлөн удирдах зөвлөл бидний давуу талд суурилсан, дэлхийн чиг хандлагад нийцсэн бодлогын томоохон баримт бичгийг баталсан.

"Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе" хэмээх стратегийн баримт бичиг нь 2030 он болон түүнээс цааших төлөвлөгөө, зорилтын бүрэн дүүрэн илэрхийлэл юм. "Оюу толгой"-д бид хөгжил дэвшлийг хамтдаа бүтээхийг чухалчилдаг. Тус стратеги нь бидний зорилгыг төгс илэрхийлээд зогсолгүй бидний хамтрагч нарын дуу хоолойг шингээснээрээ онцлог.

Бид стратегиа хувь нийлүүлэгчдийн стратеги, бодлогууд, тухайлбал Монгол Улсын дунд хугацааны зорилтот "Шинэ сэргэлтийн бодлого", урт хугацааны хөгжлийн бодлого болох "Алсын хараа-2050", мөн түүнчлэн, "Рио Тинто"-гийн зорилго, стратегид нийцүүлэн гаргасан.

Мөн өөрчлөгдөн буй дэлхий ертөнцийг илэрхийлэх, голлох хүчин зүйлс болох тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлт, өөрчлөгдөж буй дэлхий ертөнцийн дэг журам, технологи ба цахимжилт зэргийг харгалзан, болзошгүй эрсдэл болон боломжуудыг үнэлж энэхүү стратегиа шинэчлэн боловсруулсан болно.

Бидний бизнесийн үнэт зүйлс бол Санаа тавих, Зоригтой байх болон Сониуч байх бөгөөд байгууллагын стратегийн тэргүүлэх дөрвөн чиглэл нь хамт олон, хамтын ажиллагаа, хөрст дэлхий, хүртэх өгөөж юм.



Хамт олон

ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ БАЙНА

- Эрүүл, аюулгүй орчин, оролцоо ба олон талт байдлыг дэмжсэн ажлын байр, соёлыг бүрдүүлнэ
- Үе үеийн төлөөлөл бахархалтайгаар мөр зэрэгцэн ажиллах орчин нөхцөл бүрдүүлж, ур чадвартай ажилтнуудыг татаж, тогтвортой ажиллах урам зоригоор сэлбэнэ
- Дэлхийн түвшинд өндрөөр үнэлэгдэх ур чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ



Хамтын ажиллагаа

ХӨГЖИЛ ДЭВШЛИЙН ТҮНШ БАЙНА

- Хувьцаа эзэмшигч болон оролцогч талуудтай итгэлцэлд суурилсан харилцааг хөгжүүлэн төлөвшүүлнэ
- Оролцогч талуудтайгаа харилцан ашигтай зорилгын дор нэгдэнэ
- Үндэсний хэмжээнд болон орон нутгийн түвшинд эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх үйл явцыг хурдасгах зорилгоор бизнесийн түншүүдтэйгээ хамтран ажиллана
- Үйл ажиллагаа явуулж буй орон нутагт тогтвортой хөгжлийг дэмжих чиглэлээр хамтран ажиллана



Хөрст дэлхий

ЭХ ДЭЛХИЙГЭЭ ЭРХЭМЛЭН ХАМГААЛНА

- Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах дэлхий нийтийн зорилтын хүрээнд компанийн түвшинд хүлэмжийн хийг аль болох бууруулах арга замуудыг эрэлхийлнэ
- Биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хамгаалан, сайжруулна
- Компанийн үйл ажиллагаанаас газар, ус, агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах илүү оновчтой арга замыг тодорхойлно
- Улс орны хэмжээнд усны хангамж, нөөц, чанар, аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтран ажиллана
- Уурхайн хаалтын дараах нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгахад бизнесийн үйл ажиллагааг чиглүүлнэ



Хүртэх өгөөж

ТОГТВОРТОЙ ҮНЭ ЦЭН БҮТЭЭНЭ

- Урт хугацаанд үр ашгаа хүртээх, дэлхийд тэргүүлэх зэсийн үйлдвэрлэлийг цогцлооно
- Стратегийн төлөвлөгөөгөө оновчтой болгож, хүдрийн биетийн судалгаанд хөрөнгө оруулснаар үр ашгийг хамгийн боломжит дээд түвшинд хүргэж нэмэгдүүлнэ
- Нэгдмэл, уян хатан, шинийг санаачлагч байж, шинэ техник, технологи ашиглан, тасралтгүй суралцаж хөгждөг шилдэг компани байна
- Эрчим хүчний хангамж зэрэг ханган нийлүүлэлтийн сүлжээний чадамж, тогтвортой байдлыг сайжруулах, мөн дээд зэрэглэлийн бүтээгдэхүүнийг харилцагчдын хүрээг өргөжүүлэн нийлүүлнэ

МАНАЙ ҮНЭТ ЗҮЙЛС



Анхаарал халамжтай – Хамт олноо эрүүл саруул, аюулгүй байлгахад анхаарч, халамжилдаг. Бие биеэ хүндэтгэсэн, итгэлцэлд суурилсан харилцааг бэхжүүлэн, аливаа үйлдлийнхээ нөлөөллийг үргэлж ухамсарладаг. Хамт олон, хүрээлэн буй орчин, орон нутгийн иргэдийн сайн сайханд хувь нэмрээ оруулах боломжийг цаг ямагт эрэлхийлдэг.



Зоримог шийдэмгий – Бурууд нүд хурц, ёс зүйтэй байж, шаардлагатай үед шийдэмгий алхам хийж чаддаг. Бид шинийг туршихаас эмээдэггүй. Саад бэрхшээлийг хамтдаа даван туулж, нэгдмэл зорилгоо биелүүлэхийн төлөө зүтгэнэ.




Сониуч соргог – Шинэлэг санааг хөхиүлэн дэмжиж, сониуч соргог байж, хамтын хүчээр илүү ихийг бүтээхийг эрмэлздэг. Бид аливааг илүү бүтээлч, аюул осолгүй хийх арга замыг эрэлхийлж, тасралтгүй суралцдаг. Бид хамт олныхоо ололт амжилтаар хөглөгдөж, бусдаас үлгэр дуурайл авдаг.

“

**Оюу толгой илүү ээлтэй,
аюулгүй ажлын орчин бий
болгохыг зорьдог.**







Хамт олон

ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ БАЙНА


Хамт олон манай бизнесийн цөм билээ. Гайхалтай чадварлаг, тууштай хамт олон, бахархам соёл маань дэлхийн зэсийн дөрөв дэх том үйлдвэрлэгч болох гол хөшүүрэг байх болно. Өдөр бүр “Оюу толгой” компани болон гэрээт компанийн ажилчид нийлсэн 20 мянга гаруй хүн хүсэл тэмүүллээ биелүүлэхийн төлөө хөдөлмөрлөж байна.

Манай нийт ажиллах хүчний 23 хувь нь орон нутгийн иргэд буй. 2023 оны эцэст 97.2 хувьд хүрсэн дотоодын боловсон хүчний харьцаа нэмэгдэж байгаа нь манай улсын чадварлаг боловсон хүчин хамгийн сүүлийн үеийн уул уурхайн технологийн тусламжтайгаар дэлхийн жишигт нийцсэн зэсийн бизнесийг хэрхэн бүтээн байгуулж байгааг харуулж байна.

Аюулгүй ажиллах орчныг бүрдүүлж эрүүл мэнд, сайн сайхан байдлыг эрхэмлэсэн соёлыг бий болгоно

Аюулгүй ажлын орчныг бүрдүүлэх нь бидний хувьд хамгаас чухал. Хүн нэг бүр хаана ажиллаж, амьдарч байгаагаасаа үл хамааран аюулгүй ажиллагаандаа цаг гарган анхаарахыг компанийн зүгээс ухуулан дэмждэг билээ. Манай эрсдэлийн удирдлагын цогц хөтөлбөрүүд үйл ажиллагааны эрсдэлийг бууруулахад чухал үүрэгтэй. Оюу толгойн удирдах ажилтнууд 2023 онд уурхайн цогцолборын хэмжээнд 1145 ноцтой ослын эрсдэлд хяналт тавьж, ажлын байрны эрсдэлийг арилгах 235,956 магадалгаа гаргасан. Мөн аюулгүй байдал, төлөвшлийн үнэлгээг анх удаа гэрээлэгч 18 компанид хийлээ.

Монгол ажилчдын эзлэх хувь



Аюулгүй ажиллагааны соёлыг өндөр түвшинд төлөвшүүлсний ачаар бид “Рио Тинто” группийн хэмжээн дэх хамгийн аюулгүй уурхайн нэгд тооцогдож байна. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд бид Гэмтэл бэртлийн давтамжийн үзүүлэлтээ хоёр дахин бууруулж, 2023 оныг 0.20 үзүүлэлттэйгээр үдлээ. “Рио Тинто”-гийн аюулгүй ажиллагааны төлөвшлийн загвартай харьцуулсан үнэлгээ нь бидний аюулгүй ажиллагааны туршлага тасралтгүй нэмэгдэж буйг харуулж байна. Сүүлийн хоёр жилийн хугацаанд шинэ ажилчдын тоо мэдэгдэхүйц нэмэгдсэн ч энэхүү үзүүлэлтийг хадгалсаар буй нь удирдах ажилтан болон ажилчдын хичээл зүтгэлийн илрэл юм.

“Зогс, ажигла” болон “Ажлын талбар дахь манлайлал” зэрэг, аюулгүй ажиллагааг сайжруулах хэд хэдэн санаачилга нь гэмтэл бэртлээс үүдэлтэй эрсдэлийг багасгахаас гадна аюулгүй байдлын соёлыг бэхжүүлэхэд ихээхэн хувь нэмэр болж буй.

Ажилчдынхаа бие бялдар, сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдалд анхаарал тавих нь дээрхээс дутахгүй чухал. Жилийн туршид бид эрүүл мэндийн эрсдэлийн талаар олон нийтэд ухуулах кампанит ажил, сонсгол муудах, уушгины өвчин зэрэг эрсдэл аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг олгох ажил, арга хэмжээг хэрэгжүүлжээ. Бид зөвхөн олон нийтэд таниулан сурталчлаад зогсохгүй, хамт олныхоо эрүүл мэндийг идэвхтэй хамгаалахыг эрмэлзэж, цусны даралт хянах, цусан дахь сахарын шинжилгээ хийх зэрэг



Манай эрсдэлийн удирдлагын цогц хөтөлбөрүүд эрсдэлийг бууруулахад чухал үүрэгтэй

Сүүлийн 10 жилд гэмтэл, бэртэл 50% буурсан.



"Хүн нэг бүрийн санал сэтгэгдэл чухал. Бид ажилчдынхаа саналд тулгуурлан илүү ээлтэй, аюулгүй ажлын байрыг бүтээх болно."

Мелисса Шаненганге
Боловсон хүчин, бүтэц зохион байгуулалт хариуцсан Ерөнхий менежер

хэд хэдэн санаачилга хэрэгжүүлж, гэрээт байгууллагуудыг оролцуулаад 12 мянган ажилтанд хүргэсэн. Нийт ажилчдынхаа хэрэгцээ, хүсэл эрмэлзлийг онцгойлон анхаарч, ажилчдынхаа ажлын байр, амьдрах орчныг бүхэлд нь сайжруулах хүрээнд уурхайн цогцолбор дахь хөл бөмбөгийн талбайд гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж, "Манлай" спорт зааланд эрүүл мэндийг дэмжих, бие бялдрыг чийрэгжүүлэх шинэ тоног төхөөрөмж зэргийг суурилууллаа.

Бид ажлын байрны эрүүл ахуйн сөрөг нөлөөллийн эх үүсвэрийг олж илрүүлэн, үр дүнтэй хянаж баталгаажуулахын тулд гурван жилийн турш хөдөлмөрийн эрүүл ахуйн мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн нь энэ онд өндөрлөв.

Эмэгтэй ажилчдын

42% ▲

удирдах түвшний ажилтан.

Хөгжлийн бэрхшээлтэй

47 ▲
19

ажилтан

myVoice-оор

180 ▲
+67%

тохиолдол мэдээлэгдсэн

Ялгаварлан гадуурхлаас ангид, ажилчдад ээлтэй ажиллах орчны соёлыг бий болгоно

Аюулгүй, сайн сайхан байдал нь зөвхөн осол гэмтэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, багасгах тухай биш юм. Тэдэнд анхаарал халамж тавьж, хүндэтгэлтэй хандаж байгааг мэдэрсэн ажилтан илүү сайн ажиллаж чаддаг. Ажлын байран дээрээ хүйс, албан тушаал, арьсны өнгө, үндэс угсаа болон бусад шалтгаанаас үл хамааран абүгд тэгш оролцдог, хүн бүр өөрийгөө аюулгүйгээр мэдэрч, бие биеэ хүндэтгэдэг байвал хамт олон сэтгэл хангалуун байх билээ.





“

Намайг энэ салбарт ажиллаж эхэлснээс хойш уул уурхайн салбарын ажиллах орчин, хүртээмж, тэгш байдлын тухай ойлголтод ахиц гарсан. Эрх зүйн зохицуулалтын шинэчлэл нь эмэгтэйчүүдэд өмнө нь хүлээн зөвшөөрдөггүй байсан албан тушаалд ажиллах боломжийг нээсэж өгсөн. Оюу толгойн гүний уурхайд уурхайчин, оператор, цахилгаанчин гээд олон зуун эмэгтэй ажиллаж байгааг харахад үнэхээр сэтгэл хангалуун байдаг. Өдгөө манай компанийн нийт ажиллах хүчний 23 хувийг бүсгүйчүүд бүрдүүлж байна. Саяхан шинэчлэгдсэн стратегийн хүрээнд ойрын арван жилд үүнийг 30 хувьд хүргэнэ.”

*Дэйрдрэ Лингенфэлдер,
Гүйцэтгэх захирал*

2023 онд эмэгтэйчүүдийн төлөөлөл 1.3 хувиар нэмэгдэж, 23.3 хувьд хүрсэн нь дэлхийн дундаж 15 хувиас хавьгүй өндөр байна. Манай гүний уурхайд олон зуун эмэгтэй уурхайчин, оператор, цахилгаанчин гэх мэт төрөл бүрийн чиглэлээр ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны тоо өмнөх онд 28 байсан бол 2023 онд 47 болж нэмэгдсэн. Бие биеэ хүндлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих зорилтынхоо хүрээнд бид компанийн нийт ажиллах хүчний 1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдээр бүрдүүлэхийг эрмэлзэж байна.

Бид хамтдаа амжилтаа тэмдэглэж байгаа ч сайжруулах шаардлагатай зүйлс байсаар байна. Ажлын байранд тулгамдаж буй асуудлууд, түүний дотор дээрэлхэлт, бэлгийн дарамт, арьс өнгөөр ялгаварлах болон бусад төрлийн гадуурхалтыг илчлэх, илрүүлэхэд чиглэж "Рио Тинто"-гоос авсан арга хэмжээний хүрээнд Оюу толгойд ч тэвчиж үл болох тодорхой асуудлууд байгааг тогтоосон. "Оюу толгой" үүнийг үл тэвчих бөгөөд ажлын байран дахь бие махбодын болон сэтгэл зүйн аюулгүй байдлыг баталгаажуулах чиглэлээр компани даяар нэгдсэн арга хэмжээ авч ажиллах болно. "Өдөр бүр хүндэтгэе" нэртэй энэхүү тайлангийн үр дүнд бидний үнэт зүйлсийг зөрчиж буй асуудлын эсрэг яаралтай арга хэмжээ авах шаардлага буйг олж илрүүлсэн. Цаашилбал, "Оюу толгой" компани ажил

“Mongolian Talent Network” компаниас биднийг Ажиллахад хамгийн таатай компаниар Оюу толгойг шалгарууллаа

олгогчийн хувьд манай ёс зүйн хэм хэмжээг зөрчиж буй асуудлыг арилгаж, хамт олон маань асуудлыг нээлттэй хэлж чаддаг ажлын байр бий болгохыг зорьж байна. Хамт олон маань өөрсдийн дуу хоолойгоо хүргэж, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх, аюулгүй орон зайг бий болгох нь ажил дээрх зохисгүй зан үйлийг арилгахад чухал ач холбогдолтой юм. Бид дээрэлхэх, дарамтлах, ялгаварлан гадуурхах зэрэг зохисгүй зан үйлээс ангид, аюулгүй ажлын байрыг бий болгохыг 2023 онд онцгойлон анхаарсан. Үүний эхлэл болгож тодорхой чиглэлүүдийг сайжруулах талаарх ажлын хэсэг байгуулж, шаардлагатай арга хэмжээг авч эхлээд байна.

2023 онд байгууллагын бүх ахлах ажилтан, нийт ажилчдын 93 хувийг оролцуулан, ажлын байрны соёлыг сайжруулахад чиглэсэн “Өдөр бүр хүндэтгэе” сургалтыг зохион байгуулсан. Манай туслан гүйцэтгэгч, түнш байгууллагууд ч мөн адил бидний энэ зорилгод нэгдээд байна. Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш туслан гүйцэтгэгч байгууллагуудын 7,500 удирдах ажилтан манай сургалтад хамрагджээ. Сургалтууд 2024 онд үргэлжлэх бөгөөд “Ажилтнаа хүндэтгэе”, гэрээт ажилтнуудын сонсгол зэрэг шинэ сургалтуудыг нэвтрүүлэх юм. Бид мөн хүчирхийлэл дарамтад өртсөн хүмүүст туслах зорилгоор Дэмжин туслах төвийг (Care Hub)



байгуулаад байна. Эдгээр санаачилгын үр дүнд 2023 онд “myVoice” хөтөлбөрт ирүүлсэн гомдол, саналын тоо өнгөрсөн онтой харьцуулахад 67 хувиар өссөн. Цаашилбал, 2023 онд нийт 180 санал гомдлыг шалгаснаас 148 нь шийдэгдэж, 30 санал гомдлын судалгаа үргэлжилж байна. Бидний ажлын байрны соёл өөрчлөгдөн, шинэчлэгдэх цаг болсон нь үүнээс илэрхий харагдаж буй.

Нөгөө талаараа, санал гомдлын тоо эрс өссөн нь ажилтнууд маань ажлын байранд хүлээн зөвшөөрч боломгүй зан байдлыг ил тод болгох байгууллагынхаа зорилгод нэгдэн, байгууллагын зүгээс бидний үнэт зүйлийг зөрчиж байгаа үйлдлийг тэглэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авна гэдэгт итгэл хүлээлгэж буйн илрэл гэж бид ойлгож байна.

Оюу толгойн Тэтгэврийн хуримтлалын сан 7-р сарын 27-ны өдрөөс хэрэгжиж эхлэв. 2023 оны байдлаар ажилчдын 94 орчим хувь нь Тэтгэврийн хуримтлалын санд хамрагдсан байна.





2,048

2010 оноос хойш нийт 2,048 залуус Оюу толгойн Залуусын хөгжлийн хөтөлбөр, дотоод, гадаадын тэтгэлэгт хөтөлбөрийн үр шимийг хүртэв.

Үе үеийн төлөөлөл бахархалтайгаар мөр зэрэгцэн ажиллах орчныг бүрдүүлнэ

“Оюу толгой” компани улсын шилдэг ажил олгогч болох зорилготой бөгөөд ажилтан бүрийнхээ урт хугацааны санхүүгийн найдвартай байдлыг хангах алсын хараатай. Энэ дагуу Оюу толгойн Үйлдвэрчний эвлэлтэй байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд Тэтгэвэр/Хуримтлалын санг 2023 онд эхлүүлэв. 2022 оны 7-р сараас эхлэн компанийн зүгээс сар тутам ажилтны үндсэн цалингийн гурван хувьтай тэнцэх хэмжээний дүнг хуримтлалын санд төвлөрүүлэх болно.

Мөн удаан хугацааны хэлцлийн үр дүнд 2023 оны 7-р сард олны итгэлийг хүлээсэн хоёр банкттай Тэтгэвэр/хуримтлалын сангийн үйлчилгээний гэрээг байгуулсан. Ингэснээр, 2023 оны 8-р сарын 1-нээс эхлэн ажилтан бүр сайн дурын үндсэн дээр гэрээ байгуулж эхэлсэн бөгөөд ажилтан тэтгэвэрт гарах эсвэл ажил олгогчоо солих шийдвэр гаргасан тохиолдолд хуримтлалыг цаг алдалгүй бүрэн шилжүүлэн авах заалттай юм. Оны эцсийн байдлаар ажилтнуудын 94 хувь өөрсдийн нэр дээр хуримтлалын хадгаламжийн данс нээгээд байна.

Дэлхийн түвшинд өндрөөр үнэлэгдэх ур чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ

Өөрөө сурч мэдэхийн хажуугаар мэдлэг туршлагаа бусадтай хуваалцах нь бидний амжилтын үндэс. Бид илүү үр дүнтэй, аюулгүй ажиллах замаар тасралтгүй хөгжиж, мэдлэг хуримтлуулсаар байна. Манай ажиллах хүчний авьяас, ур чадвар аль хэдийн өндөр түвшинд хүрснийг дэлхийн өнцөг булан бүрээс ирж буй ажлын саналуудаас харж болно. Ур чадвараа сайжруулж, ирээдүйн уул уурхайн мэргэжилтнүүдийг бэлтгэхийн тулд бид ажилтнуудынхаа сониуч соргог байдлыг хөхиүлэн дэмжихийг онцгойлон анхаарч байна. Цогц хөтөлбөрийн дагуу ажиллах хүчнийхээ мэдлэг, чадварыг тасралтгүй хөгжүүлэхийн хажуугаар дараа дараагийн үеийн уул уурхайн салбарын мэргэжилтнүүдийг сурган хүмүүжүүлэх нь манай байгууллагын нэгэн чухал зорилго билээ. 2023 оны хувьд, ажилтнуудаа 820,412 хүн/цаг сургалтад хамруулсны зэрэгцээ олон улсын туршлага солилцох хөтөлбөрийн хүрээнд Оюу толгойн 15 ажилтныг "Рио Тинто"-гийн Канад дахь Дайвикийн очир эрдэнийн уурхайтай танилцах, туршлага солилцох аялалд хамрууллаа.



Мөн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, өндөр эрэлттэй ажиллах хүчийг бэлтгэх бидний зорилт үр дүнгээ өгч байгааг манай дөрвөн ажилтан РиоЭксперт буюу өөрсдийн мэргэжлийн чиглэлээр “Рио Тинто”-гийн хэмжээнд бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтнүүд болсноос харж болно.

Оюу толгойн мэргэжилтэн бэлтгэх цогц хөтөлбөр нь шинэ төгсөгчийн хөтөлбөр, дадлагажигч болон хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөр зэргээс бүрддэг бөгөөд 2013 оноос хойш 1558 оюутанд ажил мэргэжлийн замналаа сонгоход нь дэмжлэг үзүүлээд байна. Энэ жил л гэхэд 34 залуу ажилтан шинэ төгсөгчийн хөтөлбөрт шалгаран, мэдлэг, туршлага хуримтлуулж буй. Уг хөтөлбөрийн зорилго нь шинэ залуу ажилтнуудад хэд хэдэн газар, хэлтэс дамжин ажиллаж, олон талын туршлага хуримтлуулахын хажуугаар тусгайлан сонгосон зөвлөхүүдийн удирдлага дор ажил мэргэжлийн замналаа зөв эхлүүлж, арвин туршлагаас нь суралцах боломжийг бүрдүүлэх юм.

Дэлхийн түвшинд өндөр үнэлэгдэх ур чадвартай мэргэжилтэн бэлтгэх

бидний зорилго зөвхөн манай байгууллагын ажилтнуудаар хязгаарлагддаггүй. Үе дамнан оршин тогтнох бизнесийн хувиар, “Оюу толгой” компани Монголын уул уурхайн мэргэжилтнүүдийн шинэ үеийг бэлтгэн гаргах ажилд хувь нэмрээ оруулах ёстой. Иймд бид 410 мянган ам.долларын үнэ бүхий Геотехникийн туршилт, судалгааны лабораторийг байгуулж ШУТИС-д хүлээлгэн өглөө. Цаашлаад, бид Оюу толгойн уулын багуудтай хамтран анхан шатны дөрөв, 340 мянган ам.долларын төсөвтэй судалгааны гурван төслийг амжилттай хэрэгжүүлээд байна.

2010 оноос хойш нийт 2,048 оюутан манай Залуусыг хөгжүүлэх хөтөлбөр, Дотоод болон Гадаад тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан юм. Мөн 2016 оноос хойш нийт 537 оюутан “Говийн оюу” болон Ханбогдын оюутны тэтгэлэгт хөтөлбөрүүдэд хамрагдаад байна. Оюу толгойн Залуусын хөгжлийн хөтөлбөр, дотоод, гадаадын тэтгэлэгт хөтөлбөрийн үр шимийг 2010 оноос хойш нийт 2,048 залуус хүртэв. 2016 оноос хойш нийт Өмнөговь аймгийн 537 оюутанд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн тэтгэлэг гардуулсан.

537

2016 оноос хойш Өмнөговь аймгийн 537 оюутанд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн тэтгэлэг гардуулав.







ХАМТЫН АЖИЛЛАГАА

Бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийн төлөө хамтран ажиллана

"Оюу толгой" компани оролцогч талууд, орон нутаг болон улс орондоо урт хугацааны эерэг нөлөө үзүүлэх нэгдмэл зорилгын хүрээнд хамтын ажиллагаагаа улам бэхжүүлэхийн сацуу шинэ түншлэлийг бий болгоно. Бидний эн тэргүүний зорилт бол орон нутгийн иргэдэд үзүүлэх уурхайн үйл ажиллагааны нөлөөг доод түвшинд байлгахын зэрэгцээ хөгжил дэвшлийн хөдөлгүүр байх явдал юм.

2023 он бидний хувьд нутгийн иргэд болон бүх түвшний оролцогч талуудтайгаа харилцаа, хамтын ажиллагаагаа улам бэхжүүлж, өргөжүүлсэн жил байлаа. Үр дүнтэй хамтын ажиллагаа бол манай үйл ажиллагааны гол түлхүүр. Оролцогч талууд, нутгийн ард иргэдийн дэмжлэггүйгээр олборлолт хийх боломжгүй билээ. Бид харилцагч нэг бүртэйгээ урт хугацааны үр дүнтэй хамтын ажиллагааг эхлүүлж, тэдний хүсэл, зорилго, тэмүүллийг дэмжин ажиллаж, аливаа асуудал бэрхшээлийг даван туулахад нь тусалж, орон нутгийн соёлын өвийг хүндэтгэн хайрлах замаар хамтын ирээдүй цогцлоохоор ажиллаж байна.

Бид бизнесийн үйл ажиллагаагаа илүү нээлттэй болгож, орон нутагт илүү их хөрөнгө оруулалт, олон ажлын байр бий болгох замаар харилцан итгэлцлийг бэхжүүлж, улмаар Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулахыг зорьж буй. 2023 онд орон нутагтай хамтран ажиллах чиглэлд олон эерэг өөрчлөлт гарч, амжилттай ажилласан. Орон нутагтай холбогдох хүний нөөцийн цогц бүрдүүлэлтийн ажлын үр дүнд энэ жилийн 1-12 дугаар сард орон нутгаас Оюу толгойд ажиллаж буй хүний тоо даруй 10 хувиар өссөн бөгөөд одоогийн байдлаар ажиллах хүчний 23 хувийг орон нутгийн иргэд бүрдүүлж байна. Орон нутгийн хамтын ажиллагаандаа бид "зорилготой уулзалт, нээлттэй шийдвэр гаргах үйл явц, сайн засаглалын" зарчим баримталдаг.

"Оюу толгой" компани 2015 онд Өмнөговь аймагтай хамтран "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-г байгуулан орон нутгийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд зориулан жил бүр 5 сая ам.долларын санхүүжилтийг олгож ирсэн. Энэ хугацаанд "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-гийн дэмжин хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн үр шим давхардсан тоогоор 840 мянга гаруй хүнд хүрээд байна.



66%



Говийн Оюу
хөгжлийн
дэмжих сан

34%



ХАНБОГДЫН
ХӨГЖЛИЙН
ХУРДАСГУУР САН

2023 онд "Оюу толгой" компани тогтвортой, урт хугацааны төслүүдэд 8.2 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хийсэн.

Эрүүл мэнд	4%
Боловсрол	39%
Байгаль орчин	5%
Орон нутгийг бизнес эрхлэлтийг дэмжих	0.2%
Түүх, соёлын өв	2%
Орон нутгийн дэд бүтэц	49%
Спорт, алжаал тайлах	0.8%



**2015 онд үүсгэн
байгуулагдсан "Говийн оюу
хөгжлийг дэмжих сан"-гийн
төсөл хөтөлбөрүүдийн үр
шимийг давхардсан тоогоор
840 гаруй мянган хүн
хүртэв.**

Тус сангийн 2023 онд амжилттай хэрэгжүүлсэн тогтвортой хөгжлийн томоохон санаачилгуудаас дурдвал:

- 11-р сард 15 ортой хоёр давхар эмнэлгийг Цогт-Овоо сумд хүлээлгэн өгсөн. Уг эмнэлэг нь орон нутгийн 1600 иргэнд чанартай эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх хүчин чадалтай.
- 12-р сард Даланзадгадын дулааны цахилгаан станцын үнс зайлуулах байгууламжийг сайжруулах төсөл амжилттай хэрэгжиж дууслаа.
- “Бэлчээр усжуулалтын II аян”-ы хүрээнд 60 мянган га бэлчээрийн усан хангамжийг сайжруулж, 60 худаг бүтээн байгуулах ажлыг санхүүжүүлэв.

Шинэ сургууль, цэцэрлэг барьж, ашиглалтад оруулахын сацуу бид залуус, хүүхдүүдийн боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах төслүүд хэрэгжүүлж

**45.17 сая
ам.доллар**

2015 оноос хойш Өмнөговь аймгийн хөгжлийг дэмжих 425 төслийг 45.17 сая ам.доллаароор санхүүжүүлээд байна.

+10%

2023 оны 1-12 дугаар сарын хооронд орон нутгаас Оюу толгойд ажиллах хүний тоо даруй 10 хувиар өссөн.





Оюу толгой
Ханбогд сумыг
тогтвортой
хөгжилд хувь
нэмэр оруулна

23%

нийт ажиллах
хүчний 23% нь
орон нутгийн
иргэд байна.

2023 онд нийт

104

орон нутгийн ханган
нийлүүлэгч 272.4
сая ам.долларын
бараа үйчилгээг Оюу
толгойд нийлүүлэв.

байна. 2023 оны хэмжээнд “Говийн оюу” оюутны тэтгэлэгт хөтөлбөрт нийт 112 оюутан хамрагдаж, “Цахим багш” хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн дунд сургуулиудад 230 зөөврийн компьютер хандивлав.

2015 оноос хойш “Оюу толгой” компани “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гаар дамжуулан Өмнөговь аймгийн хөгжлийг дэмжих 425 төсөлд 45.17 сая ам.долларын санхүүжилт хийгээд байна. Бид хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдээ үр дүнтэй байлгах талаас онцгойлон анхаарч, бодит хэрэгцээ болон судалгаанд тулгуурласан аргачлалууд ашиглахыг зорьдог бөгөөд тус сангаар дамжуулан орон нутгийн сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвийн барилга байгууламжид хөрөнгө оруулалт хийсээр байна.

“Оюу толгой” компани Ханбогд сумд сүүлийн 20 жилийн хугацаанд тасралтгүй хөрөнгө оруулсаар ирсэн бөгөөд цаашдаа ч үүнийг стратегидаа чухалчлан тусгасаар байх болно. “Ханбогдын хөгжлийн мастер төлөвлөгөө” нь одоогийн сумыг иргэдийнхээ хэрэгцээг бүрэн хангасан

тогтвортой, хөгжингүй хот болон хувиргах зорилготой урт хугацааны хөгжлийн төлөвлөгөө юм.

Энэхүү зорилтынхоо хүрээнд 2022 онд “Оюу толгой” компанийн Төлөөлөн удирдах зөвлөл Ханбогдын хөгжлийг эрчимжүүлэх зорилготой “Ханбогдын хөгжлийн хурдасгуур Оюу толгой сан”-г байгуулах шийдвэр гаргасан. Энэ дагуу компанийн зүгээс Сангийн үйл ажиллагаанд зориулж таван жилийн хугацаанд 50 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийх юм. Эл төслийн эхний шат 2026 он хүртэл үргэлжилнэ.

2023 онд Ханбогдыг эрүүл, аюулгүй, иргэндээ ээлтэй хот болгох хэд хэдэн төсөл санаачилгуудыг эхлүүлсэн. Тухайлбал, 2023 онд эхэлсэн ус, бохирын шугам сүлжээний төслийн гүйцэтгэл 60 хувьд хүрэв. Галба цэцэрлэгийн таван га газрыг тохижуулах болон 7.16 км урттай авто зам, явган хүн, дугуйн зам, гэрэл, нийтийн тээврийн зогсоол зэргийг барьж байгуулах ажлуудыг мөн өнгөрсөн жил эхлүүлээд байна.

Боловсрол нь Оюу толгойн стратегийн томоохон, салшгүй нэгэн хэсэг байж ирсэн бөгөөд энэ нь бидний ирээдүй



хойч үеийнхээ хөгжилд бодитой хувь нэмэр оруулах зорилттой шууд холбогддог. Иймд Ханбогдод хийж хэрэгжүүлэх ажлын эн тэргүүнд тус сумын боловсрол, эрүүл мэндийн хүртээмжийг сайжруулах зорилт тавигдаад байна. Энэ хүрээнд бид 2023 онд сумын сургуулиудын сургалтын хөтөлбөр болон англи хэлний заах арга зүйг сайжруулах төслүүдийг эхлүүлсэн. Үүнээс гадна 2024 онд хэрэгжих томоохон санаачилгуудын суурь болох хоёр цогц судалгааг хийж гүйцэтгэлээ.

Харин нийслэл Улаанбаатар хотод ахлах сургуулийн сурагчдын нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, хүүхэд залуусын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих зорилготой



"Гэрэлт" төсөл нь 2020 онд хэрэгжиж эхэлснээс хойш 33 гаруй мянган сурагч, эцэг эх, асран хамгаалагч болон багш сурган хүмүүжүүлэгчид сэтгэлзүйн болон өсвөр үеийн нөхөн үржихүйн мэдлэг олгов.

"Гэрэлт" төсөл маань дөрөв дэх жилдээ амжилттай хэрэгжиж байна. Төслийн хүрээнд бид эрүүл мэндийн клуб, сэтгэлзүйн зөвлөгөөний танхимуудыг тохижуулан, шаардлагатай арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, дугуйлан, сургалтуудыг зохион байгуулж бөгөөд төсөл эхэлснээс (2020 он) хойш сурагч, эцэг эх, багш нийлсэн 33 мянган хүнд хүрлээ. 2023 оны 11-р сараас Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн дөрвөн сургууль дээр төслийг нэмж хэрэгжүүлэхээр болсон.

Цаашлаад, бид оюутны сургалтын тэтгэлэг, дадлагажигчийн хөтөлбөр болон боловсролын салбар дахь бусад хамтын ажиллагааныхаа хүрээнд Монголын залуу үеийнхэнд өөрсдийгөө хөгжүүлж, хүсэл мөрөөдлөө биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлсээр байна. Бид өнөөдрийг хүртэл боловсролыг дэмжих болон дотоодын мэргэжилтнүүдийн чадамжийг сайжруулах чиглэлээр 151 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгээд байна. Сургалтын тэтгэлэг болон бусад хөтөлбөрөөр дамжуулан бид маргаашийн уурхайчин, инженер, мэдээллийн технологийн эксперт, байгаль орчны мэргэжилтэн бэлтгэх ажилд хувь нэмрээ оруулдаг.

Урт хугацааны зэрэг нөлөөллийг

Би ганцаарчилсан болон багийн уулзалтад оролцсон. Энэ үеэр үе тэнгийн дарамт шахалт дээрэлхэлтийн талаар илэн далангүй яриа өрнүүлсэн. Энэ уулзалтууд нь бие биенээ хүндэтгэж сурахад чухал ач холбогдолтой.

Сурагчийн сэтгэгдэл "Гэрэлт" төсөл

Сургууль дээр мэргэжлийн сэтгэлзүйч ажиллуулахын ач холбогдол өндөр байсан. Би түүнд нууцаа хуваалцаж өөрийнхөөрөө байж чадсан. Энэ нь өөрийгөө илүү сайн таньж мэдэхэд чухал алхам болсон.

Сурагчийн сэтгэгдэл "Гэрэлт" төсөл



Аравдугаар сард Оюу толгой компани ОБЕГ-тай хамтран ажиллах ХОСБ-т гарын үсэг зурав.

авчрах үр дүнтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх нь Оюу толгойн үндсэн зорилгын нэг. 2023 онд бататгасан нэн чухал түншлэлүүдийн нэг нь Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)-тай байгуулсан хамтын ажиллагаа байлаа. Аливаа байгалийн гамшиг эрдэнэт хүний амь нас, орон гэр, эд хөрөнгийг сүйдлэн, хэлж биш хийсэж ирдэг билээ. 2023 оны 6-р сард Улаанбаатарт буусан үерээс үүдсэн хохирлыг арилгах, холбогдох дэд бүтцийг сайжруулах хүрээнд “Оюу толгой” компани ОБЕГ-т 864 сая төгрөгтэй дүйцэх эд материалын хандив өгч, БНТУ-д болсон газар хөдлөлтийн гамшгаас сургамж аван 7-р сард газар хөдлөлтийн талаар мэдлэг, мэдээлэл өгөх “Бэлэн бай” кампанит ажлыг орон даяар зохион байгууллаа. Мөн оны 10-р сард “Оюу толгой” компани ОБЕГ-тай цаашид хамтран ажиллах Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Ирэх онд бидний хамтын ажиллагаа байгалийн гамшгийн

удирдлага, бэлэн байдлын чиглэлд үргэлжилнэ.

Манай хамтын ажиллагаа бүхий сумдад амьдарч байгаа 1250 гаруй малчин өрхийн амьжиргааны эх үүсвэр нь бэлчээрийн мал аж ахуй хэвээр буй. Эдгээр сумд нийт 626,900 толгой мал тоолуулсан ч цаг агаарын хүнд нөхцөлөөс шалтгаалан олон мал эндэж, амьд үлдсэн мал нь нэмэлт тэжээл, асаргаагүйгээр ирэх өвлийг давахааргүй нөхцөлд хүрсэн юм. Бид 340 сая төгрөгийн үнэ бүхий малын тэжээлийг зуданд өртсөн малчин өрхүүдэд хандивлалаа.

Үндэсний худалдан авалтын сүлжээг цогцлоох нь

Үндэсний худалдан авалтын сүлжээг хөгжүүлэн нэвтрүүлэх нь манай байгууллагын хамтын ажиллагааны нэн чухал хэсэг. Энэ оны байдлаар “Оюу толгой” ХХК-ийн дотоодын худалдан авалт 89.2 хувьд хүрсэн бөгөөд цаашид энэ тоог нэмэгдүүлэх зорилготой ажиллаж байна. 2023 оны эцэст “Оюу толгой” ХХК 969 ханган нийлүүлэгчтэй хамтран ажилласны 700 нь дотоодын ханган нийлүүлэгч юм. 2010 оноос хойш дотоодын худалдан авалтад 28.2 их наяд төгрөгийг зарцуулаад байна. 2023 оны эцэст Өмнөговь аймагт бүртгэлтэй 104 ханган нийлүүлэгчээс 945.3 тэрбум төгрөгийн бараа, үйлчилгээ авлаа. 2010 оноос хойш Өмнөговь аймгаас нийт 3.9 их наяд төгрөгийн худалдан авалт хийгээд байна.

“Оюу толгой” ХХК-ийн гадаадын импортыг орлуулах зорилготой хэрэгжүүлж байгаа “Монголд үйлдвэрлэв” санаачилга мөнгөний урсгалыг дотооддоо үлдээж, үндэсний





үйлдвэрлэлийг хөгжүүлэн дэмжихэд ихээхэн үүрэг гүйцэтгэсээр буй. 2017 онд хэрэгжүүлж эхэлснээс хойш, “Монголд үйлдвэрлэв” санаачилгын ачаар 20 орчим жижиг, дунд хэлбэрийн үйлдвэр ашиглалтад ороод байна. Эдгээр үйлдвэр нь ажлын дүрэмт хувцас, өвлийн бээлий, ажлын гутал, хамгаалалтын малгайнаас эхлээд тээрмийн бөмбөлөг, радио пайз, 2 тоннын баяжмалын уут зэргийг бахархалтайгаар үйлдвэрлэж байгаа юм.

Оролцогч талуудын харилцааг дараагийн түвшинд хүргэх

Манай уурхайн олборлолт он удаан үргэлжлэх учир бид харилцагч, түншүүдтэйгээ үр дүнтэй харилцаа, хамтын ажиллагааг цогцлоох зайлшгүй шаардлагатай. Аль болох өндөр өгөөжийг оролцогч талууддаа хүргэх бидний зорилго зөвхөн орон нутагт хэрэгжих санал санаачилга, төсөл хөтөлбөрөөр хязгаарлагдах ёсгүй.

Орон нутгийн ард иргэдийн санал, санаа бодол, хүсэл эрмэлзлийг сонсох нь үүнд нэн чухал. Бид Ханбогдын Гурван талт зөвлөл болон бусад мэдээлэл солилцох арга хэмжээний хүрээнд орон нутгийн иргэдтэй бэхжүүлсэн хамтын ажиллагаагаа амжилттай үргэлжлүүлсээр байна. Өнгөрсөн жилийн хугацаанд Орон нутгийн харилцааны хэлтэс 610 арга хэмжээний хүрээнд орон нутгийн 1138 иргэнтэй харилцан ажиллав.

Цаашид засаж сайжруулах зүйл их байгаа тул бид орон нутагтай үргэлжлүүлэн нягт хамтран ажиллах болно. Энэ жилийн хувьд бид 18 гомдол санал хүлээж авснаас 15-ыг нь бүрэн шийдвэрлээд байна. Бид орон нутгийн иргэдийн санал сэтгэгдэл бүрд өндөр ач холбогдол өгч, үр дүнд суурилсан нээлттэй яриа хэлэлцээг тасралтгүй үргэлжлүүлэхийг эрмэлздэг билээ.







Хөрст дэлхий

Байгаль орчноо эрхэмлэн
хамгаална

Хүн төрөлхтөнд цор ганц байгаль дэлхийгээ дээдлэн хамгаалж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах нь бидний үүрэг хариуцлагаас гадна нийгмийн зүгээс бидэнд даалгаж буй хүлээлт билээ.

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах дэлхий нийтийн зорилгод хувь нэмрээ оруулна.

Бидний оршин буй дэлхий ертөнцөд гүн гүнзгий өөрчлөлтүүд өрнөж байна. Тулгамдсан сорилтууд, тэр дундаа уур амьсгалын өөрчлөлт биднээс ажлын арга барилаа өөрчлөн шинэчлэх, сайжруулан засахыг шаардаж байна. Уур амьсгалын өөрчлөлт бол хөрст дэлхийд тулгамдаж буй ноцтой асуудал учир “Оюу толгой” байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын сацуу хүлэмжийн хийн ялгарлыг багасгах дэлхий дахины зорилгод хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж байгаа болно.

Одоогоор бидний ялгаруулж буй нүүрстөрөгчийн давхар исэл (CO₂)-ийн 70 орчим хувь нь эрчим хүчний хэрэглээнээс, 20 орчим хувь нь дизель түлшний ашиглалт, харин үлдсэн 10 хувь нь бусад эх сурвалжаас ялгарч байна. Хүлэмжийн хийг бууруулах зорилгын хүрээнд бид өөрсдийн ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээг тууштай бууруулж, улмаар 2050 он гэхэд тэглэх зорилт тавьсан. “Оюу толгой” компани одоогийн хүлэмжийн хийн ялгарлаа 2030 он гэхэд 30 хувиар бууруулах зорилт тавин, энэ зорилтдоо хүрэх арга замыг боловсруулаад байна.

Бүс нутгийн биологийн төрөл зүйлийн олон янз байдал, байгаль орчноо хамгаалан сайжруулна

Биологийн төрөл зүйлийн олон янз байдлын алдагдал хийгээд уур амьсгалын өөрчлөлтийн холбоо хамаарал бүхий нөлөөлөл нь нутгийн зон олон болон байгаль орчинд ноцтой эрсдэл учруулж байна. Бид үйл ажиллагааныхаа байгальд үзүүлж буй сөрөг нөлөөг бодитоор бууруулах үүрэг хариуцлагатайн зэрэгцээ бизнесийн үйл ажиллагаа маань эрүүл экосистемээс хамааралтайг ямагт ухамсарладаг. Экологийн тэнцвэрт байдал бүхий байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийг даван туулахад нэн чухал үүрэгтэй. Энэ нь орон нутгийн иргэдэд ч, бидний үйл ажиллагаа явуулж буй орчинд ч, манай бизнесийн үйл ажиллагаанд ч онцгой ач холбогдолтой.

Бид биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хамгаалан сайжруулахад хүчээ дайчлан ажиллаж байгаа бөгөөд цэвэр дүнгээр сөрөг нөлөө үзүүлэхгүй байхыг эрмэлзэж байна. Үүний тулд биологийн төрөл зүйлийн олон янз байдалд үзүүлж буй сөрөг нөлөө болон түүнийг бууруулахад чиглэсэн арга хэмжээний зохист харьцааг олох хэрэгтэй.

Бид 2036 он гэхэд биологийн төрөл зүйлийн олон янз байдалд цэвэр дүнгээр эерэг нөлөө үзүүлэх зорилт тавьсан. Харин ойрын хугацаанд буюу 2024-2025 онд энэхүү зорилтын биелэлтийг 30 хувьд хүргэхээр ажиллаж байна. Ингэснээр үйл ажиллагааныхаа байгаль орчинд учруулах нөлөөг багасгахын сацуу байгаль орчныг хадгалан хамгаалахад ихээхэн хувь нэмэр болох юм.



Нөхөн сэргээгдсэн Ялбаг голын хөндий, Сэлэнгэ аймаг

Одоогоор энэ үзүүлэлт 21 хувьтай байна.

“Оюу толгой” компани 2023 онд нийт 45.45 га газарт биологийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлт хийгдсэн 51.76 га газарт нэмэлт сэргээлт, Оюу толгойгоос Гашуунсүхайд чиглэлийн авто замын карьер болон Гүний хоолой орчмын 64.34 га газарт техникийн нөхөн сэргээлт хийсэн. Байгаль орчноо эрхэмлэн хамгаалах бидний ажил гагц манай үйл ажиллагаа явуулж буй нөлөөллийн бүсээр хязгаарлагдахгүй. Тодруулбал, 2023 онд Сэлэнгэ аймагт бичил уул уурхайн үйл ажиллагаанаас болж эвдэгдэж сүйдсэн 400 га газарт техникийн нөхөн сэргээлт хийхийн сацуу түншлэгч талуудтай байгуулсан хамтын ажиллагаагаа өргөжүүлсэн юм.

“Оюу толгой” ХХК Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай 11 дүгээр сарын 24-ний өдөр нэмж 187 га газарт нөхөн сэргээлт хийх Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан нь энэ чиглэлээрх онцлох нэгэн мөч байлаа.

400 га

эвдэгдсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийв.

10.8 сая

модтой дүйцэхүйц ажил, арга хэмжээ гүйцэтгэв.





Говьд нутагт бэлчих хулан

Бид мөн хог хаягдлын менежментэд ихээхэн анхаарч ирсэн. Тайлант хугацаанд нийт хог хаягдлын 61 хувь нь дахин боловсруулагдах хог хаягдал байв. Бид өнгөрсөн жил хог хаягдал дахин боловсруулах чиглэлд үйл ажиллагаа эрхэлдэг үндэсний 17 компанитай хамтран ажиллалаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Оюу толгой” компани 100 сая мод тарих амлалт өгснөөсөө хойш нийт 190 мянган мод тарьснаас гадна 10.8 сая мод тарьсантай дүйцэх хэмжээний ажил хэрэгжүүлсэн. Тухайлбал, 2023 онд Өмнөговь аймгийн Ханбогд болон Цогт-Овоо сумд тус тус жилийн 250 болон 500 мянган тарьцын хүчин чадалтай мод үржүүлгийн газар байгуулав.

Цаашилбал, биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг хамгаалах хөтөлбөрийн хүрээнд биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийг шатлан бууруулах зорилго тавин ажиллаж, үүгээрээ манай үйл ажиллагааны улмаас Өмнөговь аймгийн биологийн төрөл зүйлд учрах эрсдэлээс зайлсхийх, доод түвшинд байлгах, бууруулахыг зорьж байна. Энэ хүрээнд бид жилийн турш биологийн олон янз байдалд хяналт тавьсан. Эл мониторингод ургамал, зэрлэг ан амьтан буюу шувуу, хэвлээр явагчид багтаж байгаа юм.

Өнгөрөгч 2023 онд хулан болон хар сүүлтийн нүүдлийн хөдөлгөөний талаар томоохон судалгаа хийгдэв. Судалгааны үр дүнд эдгээр хөхтөн амьтан цаг уур, бэлчээр болон ундны усны хүрэлцээнээс хамаарч 210- 23763 км квадрат газарт нүүдэллэн амьдарч буйг тодорхойлсон. Энэхүү судалгаа нь биологийн төрөл зүйлийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахад чиглэсэн ирээдүйн арга хэмжээнд чухал ач холбогдолтой юм. Цаашилбал, төр засгаас авч хэрэгжүүлэх дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөвлөгөөг авч хэлэлцэхэд чухал судалгааны материал болох билээ.

Усыг үр ашигтай зарцуулах чиглэлд тэргүүлсэн хэвээр байна.

Ус бол амьдралыг тэтгэх чандмань эрдэнэ билээ. Бидний үйл ажиллагаа явуулж буй говийн бүс нутгийн зон олонд ус хамгаас илүү үнэ цэнтэй. Говь нутаг маань онцгойлон анхааруштай өвөрмөц эмзэг тогтоцтойг бид ухамсарлаж, ус үр дүнтэй зарцуулах болон хог хаягдлыг дахин ашиглах чиглэлд дэлхийн жишиг уурхай буйгаа хэвээр хадгалахыг стратегийн зорилгоо болгон ажиллаж байна. Оюу толгой дэлхийн хэмжээнд ус хамгийн үр ашигтай хэрэглэдэг зэсийн уурхай нэг хэвээр байгаа юм. 2023 оны эцсийн байдлаар бид нэг тонн хүдэр боловсруулахад 0.39 шоо метр ус зарцуулсан нь дэлхийн зэсийн уурхайнууд дундаа жишиг үзүүлэлт билээ. Мөн 2023 оны байдлаар ус дахин ашиглалтын зорилтот түвшин болох 80 хувийг давуулан биелүүлж, 85.74 хувьд хүргэлээ.

“Хаягдал хадгалах байгууламж 1”- ийн шүүрэлд “Оюу толгой” хяналт тавин ажиллаж байна. Бид өнгөрсөн жилийн хугацаанд орон нутгийн болон улсын хэмжээний холбогдох оролцогч талуудтай тогтмол харилцаж, зөвшилцөн ажилласан. “Хаягдал хадгалах байгууламж

1"-ийн шүүрлийг бууруулах зорилго бүхий "Сөрөг нөлөөг бууруулах цогц арга хэмжээний төлөвлөгөө"-ний хүрээнд урт хугацааны гидрогеологийн судалгаа, ирээдүйн загвар болон инженерчлэлийн чиглэлд арга хэмжээ авч, долоо хоног тутам үйл ажиллагаагаа тайлагнаж буй. Оюу толгой дахь шүүрлийн асуудал хариуцсан ажлын хэсгийн хэрэгжүүлж буй энэхүү төлөвлөгөөний биелэлтэд Рио Тинтогийн байгаль орчны мэргэжилтнүүдээс гадна зээлдэгчдийн өмнөөс байгаль орчин, нийгмийн хараат бус зөвлөхүүд хяналт тавьж байгаа болно.

Авсан арга хэмжээний дүнд хяналтын цооног дахь нийт уссан давс (total dissolved salt)-ны түвшин аажмаар буурч байна. "Хаягдал хадгалах байгууламж 1" болон шинээр ашиглалтад орсон "Хаягдал хадгалах байгууламж-2"-ийн суурь бүтэцтэй холбоотой ямар нэг хүндрэл гараагүй.

"Хаягдал хадгалах байгууламж 1"-ийн шүүрэл нь малчид болон бусад хэрэглэгчдийн ундны усанд сөрөг нөлөө үзүүлээгүйг мониторингийн мэдээлэл баталж байгаа юм.



Оюу толгойн хаягдал хадгалах байгууламж





ХӨН тээрэмд хуваарьт засвар, үйлчилгээ хийгдэж байгаа нь



ХҮРТЭХ ӨГӨӨЖ

Тогтвортой үнэ цэн бүтээнэ

Оролцогч талуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд бизнес маань юуны өмнө ашигтай ажиллах ёстой. Бид хүдрийн биетийн судалгаа, мэдлэгээ зузаатгахын хэрээр олборлолт, үйлдвэрлэлийн төлөвлөгөөг улам оновчтой болгоно.

Үнэ

Зэсийн үнэ 2023 оны эцэст тонн тутамд 8,532 ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар буурав. БНХАУ-д цар тахлын хорио цээрийн дэглэм сулрах хүлээлттэй холбоотойгоор нэгдүгээр улиралд зэсийн үнэ тонн тутамд 9,436 ам.доллар хүртэл өссөн ч сүүлийн улирал гэхэд тонн тутамдаа 7,813 ам.доллар болж буурсан нь хөрөнгө оруулагчид зэсийн үнийг 2020 оноос хойш ажиглагдаагүйгээр буурна гэж үзсэнтэй холбоотой. Харин Өмнөд Америкт үйл ажиллагаа явуулж буй хэд хэдэн уурхайн үйл ажиллагаа доголдсон, олборлолтын зардал нэмэгдсэн хийгээд нөөцийн түвшин багассантай холбоотойгоор зах зээлийн хүлээлт сайжрав.

Алтны үнэ өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 8 хувь өсөж, унц нь 1,941 ам.долларт хэлбэлзэв. АНУ-ын Нөөцийн сангийн бодлогын хүүтэй холбоотойгоор алтны үнэ Нэгдүгээр улиралд унц нь 1800 ам.долларт шүргэж, улмаар жилийн эцэс дөхөхөд огцом өсөн, шинэ дээд үнэ тогтоолоо. Энэ өсөлтийг БНХАУ-ын Төв банкны худалдан авалт, Ойрх Дорнодод үүсээд буй геополитикийн тогтворгүй байдал болон 2024 онд хүүгийн түвшин буурах хүлээлттэй холбоотой гэж үзэж байна.

Үйлдвэрлэл

Ил уурхайгаас зөөвөрлөсөн чулуулгийн хэмжээ 2022 онд 97.4 сая тонн байсан бол 2023 онд 93.4 сая тонн болж буурсан нь ил уурхайн доголыг засаж сайжруулах үйл ажиллагаа болон тоног төхөөрөмжийн ашиглалт төлөвлөснөөс бага байсантай холбоотой. Таамаг нөөцөнд тооцогдсон хүдрийн зарим хэсэг нь агуулгаараа хүдэрт шилжсэн болон гүний уурхайгаас ирэх хүдрийн гаралт нэмэгдсэн нь бага агуулгатай овоолгын дахин ашиглалтыг бууруулж, дахин тээвэрлэгдэх материалын хэмжээг 2022 онтой харьцуулахад 3.1 сая тонноор багасгах боломж олгов.

Гүний уурхайн үйл ажиллагаанд өндөр ахиц гарч, 2023 оны 3 дугаар сард тогтвортой үйлдвэрлэл эхэлсэн. 2023 онд 55 хүдэр буулгуурын тэсэлгээг гүйцэтгэнэ гэсэн төлөвлөгөөг давуулан биелүүлж, 67 тэсэлгээ хийсэн бөгөөд оны төгсгөлд Хойд Хюго дахь "Панель 0"-ийн нийт 86 хүдэр буулгуурын тэсэлгээг амжилттай гүйцэтгэв. 2023 оны эцсийн байдлаар "Панель 0"-н бүтээн байгуулалтын ажлын 70 хувийг хийж гүйцэтгээд байна. 2022 онд боловсруулсан хүдрийн хэмжээ жилийн зорилт болох 39.1 сая тонныг давж 39.3 сая тоннд хүрэв. Гүний уурхайн өндөр агуулгатай хүдрийн хэмжээ 2022 оныхоос даруй хоёр дахин нэмэгдэж 3.4 сая тоннд хүрсэн бөгөөд өнгөрсөн жил боловсруулсан нийт хүдрийн 9 хувь нь гүний уурхайнх байв. Цаашид энэ үзүүлэлтийг 2024 онд 17 хувь, 2028 он гэхэд 50 хувьд хүргэх зорилт тавьж, шаардлагатай бэлтгэл ажлыг амжилттай гүйцэтгэж байгаа болно. Тодруулбал, гүний уурхайгаас газрын гадарга руу хүдрийн материалыг зөөвөрлөх үйл ажиллагааг сайжруулах зорилготой нэмэлт туузан дамжуургуудыг угсрах ажил 2023 оны жилийн эцсийн байдлаар 88 хувьтай байна.

Бид 2023 онд нийт 795.7 мянган тонн баяжмал үйлдвэрлэж, 658,000 тонн үйлдвэрлэх төлөвлөгөөгөө давуулан биелүүллээ. Тайлант хугацаанд мөн зэс, алт үйлдвэрлэх төлөвлөгөө бүрэн биелэв. Тодруулбал, үйлдвэрлэлийн төлөвлөгөө зэсийн хувьд 5 хувь, алтны хувьд 15 хувь тус тус давав. Энэ нь гүний




Oyu Tolgoi's Concentrator Plant

уурхайгаас олборлох өндөр агуулга бүхий хүдрийн хэмжээ нэмэгдсэнтэй шууд холбоотой.

Оюу толгойн баяжмал үйлдвэрлэл өссөн, мөн БНХАУ дахь цар тахлын эсрэг хорио цээрийн дэглэм өнгөрөгч оны дөрөвдүгээр сард цуцлагдаж, улмаар зэсийн үйлдвэрүүд рүү хийгдэх тээвэрлэлт нэмэгдсэн зэрэг нь борлуулалтын орлого 2022 оныхоос илүү гарах шалтгаан болсон. 2023 онд “Оюу толгой” компани 166 мянган тонн зэс (2022 онд 132 мянган тонн), 175 мянган унц алт (2022 онд 207 мянган унц), 1,008 мянган унц мөнгө (2022 онд 836 мянган унц) тус тус агуулсан 823 мянган тонн баяжмал (2022 онд 661 мянган тонн) борлуулж, 1 тэрбум 625 сая ам.долларын (2022 онд 1 тэрбум 424 сая ам.доллар)-ын орлого олсон. Энэхүү амжилт нь гүний уурхайн өндөр агуулгатай хүдрийн материал, металл ялгалтын хувь өндөр байсан зэрэг хүчин зүйлээс шууд шалтгаалж байгаа юм.

Баяжмал борлуулалт

(мянган тонноор, хуурай)



Өмнөх онтой харьцуулбал баяжмалын борлуулалт мэдэгдэхүйц нэмэгдэв. Нийт борлуулалт 823 мянган тоннд хүрэв.

Сая ам.доллар	2023	2022	2021	2020	2019	2018
Борлуулалтын орлого	1,625	1,424	1,971	1,078	1,166	1,180
Үндсэн үйл ажиллагааны, татвар, хүү, элэгдлийн өмнөх ашиг*	574	436	1,205	379	350	367
Үндсэн үйл ажиллагааны, Татвар, хүү, элэгдлийн өмнөх ашгийн хувь (хувь)*	35%	31%	61%	35%	30%	29%
Урсгал капиталын зардал	150	152	89	59	134	91
Гүний уурхайн капитал зардал	567	492	621	914	1,194	1,234
Гүний уурхайн урсгал капиталын зардал	531	433	238	97	-	-
Улсад төлсөн татвар, шимтгэл, бусад төлбөр**	297	207	593	200	209	200

* Орлогын татвар, Хүүгийн зардал, Элэгдэл, Хорогдлыг тооцохын өмнөх үндсэн үйл ажиллагааны ашиг нь орлогын тайланд тусгагдсан орлогын татвар, санхүүгийн цэвэр зардал, элэгдэл, хорогдлын зардлыг тооцохын өмнөх ашгийг харуулах ба энэ дүн нь үнэ цэнийн бууралтын ямар нэгэн нөлөөг агуулаагүй болно.

** НӨАТ ороогүй дүн. “Оюу толгой” ХХК НӨАТ-ын буцаан авалт хийдэггүй.



86 хүдэр юүлүүр

2023 онд 55 хүдэр юүлүүрийн тэсэлгээ хийхээр төлөвлөснөөс 67 амжилттай гүйцэтгэв. Панел 0-ийн нийт хүдэр юүлүүрийн тэсэлгээ 86 хүрэв.

15,692м

2023 онд гүний уурхайн бүтээн байгуулалт урагшилж, хөндлөн малталт 15,692 метрээр ахив.

Урсгал капиталын зардал

Урсгал капиталын зардал 2022 онд 152 сая ам.доллар байсан бол өнгөрөгч онд 150 сая ам.доллар болж ялимгүй буурав. Энэ нь Гашуунсухайт чиглэлийн авто зам болон хаягдлын далангийн барилгын зардал (нийт 25 сая ам.доллар) тооцоолсноос бага байсантай холбоотой бөгөөд эдгээр ажлын ихэнх нь 2022 онд хийгдэж дууссан юм. 2022 онд зөөвөрлөсөн хаягдал материалтай холбоотойгоор хөрс хуулалтын хойшлуулсан зардал 3 сая ам.доллараар буурсан нь мөн үүнд нөлөөлсөн. Гэсэн хэдий ч тоног төхөөрөмжийн шинэчлэл, засварын зардал (2022 оныхоос 27 сая ам.доллараар илүү байв) зэрэг нь зардлын зөрүү буурахад шууд нөлөөлөв.

Гүний уурхайн капитал зардал

2023 онд гүний уурхайн бүтээн байгуулалтын капитал зардал 567 сая ам.доллар буюу 2022 оныхоос 75 сая ам.доллараар их байгаа нь оны эхний хагаст уурхайн талбар дахь ажил эрчимжсэн хийгээд Хөдөлмөрийн тухай хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор бий болсон цалингийн зардал зэргээс шалтгаалсан байна. 2016 оны нэгдүгээр сараас хойш тайлант хугацаанд гүний уурхайн төсөлтэй холбоотой гарсан нийт зардал 6.07 тэрбум ам.долларт хүрсэн. Төслийн хүрээнд байгуулсан нийт гэрээ

хэлцлийн дүн 6.71 тэрбум ам.доллар бол үүнээс 4.95 тэрбум ам.долларын гэрээ хэлцлийг дотоодын ханган нийлүүлэгчидтэй байгуулснаар 2016 онд анх тавьсан 1.4 тэрбум ам.доллар, 2018 онд шинээр тавьсан 2.0 тэрбум ам.долларын зорилтоо давуулан биелүүллээ. Шууд гэрээний хувьд нийт 1.42 тэрбум ам.долларын дүн бүхий гэрээг олон улсын ханган нийлүүлэгчидтэй байгуулсан байна. Худалдан авах ажиллагаа, гэрээний багцуудаар дамжуулан дотоодын ханган нийлүүлэгчдэд зарцуулсан дүн нь төслийн худалдан авах ажиллагааны нийт дүнгийн 78 хувийг эзэлж байна.

Гүний уурхайн урсгал капитал зардал

Гүний уурхайн урсгал капитал зардал 2023 онд 531 сая ам.доллар байсан нь 2022 оноос (433 сая ам.доллар) даруй 98 сая ам.доллараар өссөн дүн юм. Энэ нь огтлох малтлага болон хүдэр буулгуурын тэсэлгээний ажил (19 тэсэлгээ хийхээр төлөвлөсөн ч 67 тэсэлгээ хийсэн) эрчимжсэн нь газрын гадарга руу гаргах материалын хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотой юм.

Гүний уурхайн бүтээн байгуулалт

2023 онд гүний уурхайн хөндлөн малталт 15,692 метрээр ахив. Гүний уурхайн бүтээн байгуулалтын хүрээнд зөөвөрлөсөн нийт

материалын хэмжээ 2022 оныхоос 1,415 мянган тонноор илүү байв (2023: 3,568 мянган тонн - 2022: 2,153 мянган тонн). Энэ нь материалын зөөвөрлөлт нэмэгдэж, хүнд даацын хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн ашиглалт идэвхжиж, улмаар сэлбэг, тос тосолгооны материалын хэрэглээ өссөн зэргээс шалтгаалсан. Үүнээс гадна, "Хөдөлмөрийн тухай хууль"-д нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор цалингийн зардал 2022 оныхоос 16 хувиар (17 сая ам.доллар) өсөв. Хүдэр ачих хоёр гулсуур амжилттай угсрагдаж, өнгөрсөн онтой харьцуулахад төмөр хийцийн угсралтын гүйцэтгэл 180 хувиар өсөж, үйлчилгээний болон цахилгааны угсралтын ажлын гүйцэтгэл даруй гурав дахин нэмэгдсэн. Мөн зөөвөрлөх болон тээвэрлэх түвшний дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлууд 2022 оны гүйцэтгэлээс давсан амжилт үзүүлэв.

Татвар, шимтгэл, бусад төлбөр

2023 онд Монгол Улсын Засгийн газарт татвар, шимтгэл, бусад төлбөрт (дотоод худалдан авалтад төлсөн НӨАТ-ыг оруулахгүйгээр) 297 сая ам.доллар төлсөн нь 2022 оныхоос (207 сая ам.доллар) 90 сая ам.доллараар илүү байна. Үүнд гүний уурхайн хөрөнгөтэй холбоотой үл хөдлөх хөрөнгийн татварын төлбөр, татварын хувь өндөр байгаа болон ажиллах хүчний зардалтай холбоотой зардал нэмэгдсэн зэрэг голчлон нөлөөлөв.

"Оюу толгой" компани 2023 онд Гүний уурхайн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх, төслийн санхүүжилтийн зээлийн хүүг төлөх зорилгоор 1,061 тэрбум ам.долларын (2022 онд 1,542 сая ам.доллар) санхүүжилт татсан. Санхүүжилтийн 211 сая ам.долларыг баяжмал борлуулалтын урьдчилгаа төлбөр, 850 сая ам.долларыг шинэ


Спонсорын давуу эрхтэй зээл хэлбэрээр татсан (2022 онд хувь нийлүүлэгчдийн зээл 153 сая ам.доллар, баяжмал борлуулалтын урьдчилгаа төлбөр 1,389 сая ам.доллар тус тус байв). Оны эцэст нийт зээлийн хэмжээ 16.45 тэрбум ам.доллар байлаа.

Мөнгөн хөрөнгө нэмэгдүүлэх хөтөлбөрүүд

Оюу толгойн үнэ цэнийг нэмэгдүүлэх замаар хувь нийлүүлэгчдийн үр өгөөжийг өсгөх нь бидний зорилго билээ. Бид компанийн хэмжээнд хэрэгжүүлж буй "Бизнес шинэчлэлтийн хөтөлбөр"-ийн хүрээнд "эзний ёсоор хандах" соёлыг уурхай даяар төлөвшүүлж, Оюу толгойд үлдэх үр өгөөжийг нэмэгдүүлсээр байна. Энэ соёл нь бизнесийн үнэ цэнийг өсгөх, байгууллагын бүтэц зохион байгуулалтыг сайжруулахад чиглэсэн санал санаачилга гаргах боломжийг ажилчдад олгодог юм. Тус хөтөлбөр анх 2017 онд хэрэгжиж эхэлснээсээ хойш орлого нэмэгдүүлэх, үйл ажиллагааны зардал бууруулах, ажлын цэвэр капитал болон капиталын урсгал зардал хэмнэх зэрэг үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон санаачилгын эх болж, үр дүнд нь 2017- 2023 онд ойролцоогоор 1.87 тэрбум ам.долларын өгөөж авчирчээ.

"Бизнесийн боломжийг бүрэн дайчлах", "Шинэ санаа гаргах" зэрэг семинар зохион байгуулж, дорвитой сайжруулалт хийх арга зам, санал, санаачилгуудыг тодорхойлж, бизнес шинэчлэлтийн хөтөлбөрийн мэдээллийн сан бүрдүүлэн, "Моментум" системд эдгээр санаа, санаачилгуудыг бүртгэж, явцыг нь тайлагнаж байна. Санаачилга дэвшүүлсэн ажилчдын хүчин чармайлт, хөдөлмөрийн үр дүнд бид 2023 онд 267 сая ам.доллар хэмнэж, мөн онд тавьсан 252 сая ам.долларын зорилтоо давуулан биелүүллээ.

"Бизнес шинэчлэлтийн хөтөлбөр"-ийн үр дүн, 2023 онд



2023 оны гол амжилтуудыг дурдвал:

- » “Эзний сэтгэлгээ”-г төлөвшүүлэх, асуудал шийдвэрлэх ур чадварыг эзэмшүүлэхэд үргэлжлүүлэн анхаарав.
- » Хөтөлбөрийн үйл явцын нарийвчлал боловсронгуй болсоор байна.
- » Оролцогч талуудын идэвхтэй оролцоог ханган, нягт хамтран ажиллав.
- » “Бизнесийн боломжийг бүрэн дайчлах семинар”-ыг анх удаа гүний уурхайн ажилтнууд дунд зохион байгуулав.
- » “Шинэ санаа гаргах семинар”-ыг нийт 25 удаа, “Бизнесийн боломжийг бүрэн дайчлах семинар”-ыг 2 удаа тус тус зохион байгуулж нийт 284 ажилтныг хамруулав.
- » Нийт 150 ажилтнаас сайжруулалт хийхтэй холбоотой 257 санал, санаачилга хүлээн авав.
- » Хэлтсүүдийн долоо хоног тутмын зардлыг илүү сайн хянадаг болов.
- » Хөтөлбөр, амжилт сайшаах системийг нэвтрүүлж 16 арга хэмжээний хүрээнд 31 санаачилгыг тодотгон 349 ажилтныг урамшуулснаас 5 санаачилгыг нь “Рио Тинто”-гийн Зэсийн группийн шагналд тодорхойлсон.







Эрчим хүч

2009 онд байгуулсан Оюу толгойн "Хөрөнгө оруулалтын гэрээ"-нд Оюу толгойн эрчим хүчний хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангахаар заасан байдаг. Энэ хүрээнд Оюу толгойн төдийгүй улс орны эрх ашгийг хангах цахилгаан эрчим хүчний оновчтой шийдлийг олохоор "Оюу толгой" ХХК-ийн зүгээс Монгол Улсын Засгийн газартай нягт, тууштай хамтран ажилласаар ирсэн билээ. Улмаар, 2022 оны 1 дүгээр сард "Оюу толгой" ХХК болон Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээнээс Оюу толгойн уурхайг урт хугацаанд "Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ"-нд гарын үсэг зурсан.

2023 онд гарсан ахиц дэвшил

Цахилгаан эрчим хүчээр хангах худалдан авах гэрээ

БНХАУ-ын "Өвөр Монголын Эрчим хүчний олон улсын хамтын ажиллагаа" корпорацитай өрнүүлсэн яриа хэлэлцээ, түүний үр дүнд байгуулсан цахилгаан импортын гэрээ нь Оюу толгойг цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах чиглэлд 2023 онд гарсан томоохон дэвшил байлаа. Ийнхүү 2020 оны дунд үеэс эхэлсэн, эрчим хүч үргэлжлүүлэн импортлох тухай яриа хэлэлцээ хоёр жил хагасын уйгагүй хүчин зүтгэлийн үр дүнд амжилт оллоо. Монгол Улсын "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" ТӨХК, Эрчим хүчний яамтай хамтран БНХАУ-ын "Өвөр Монголын

Эрчим хүчний олон улсын хамтын ажиллагаа" корпорацитай хэд хэдэн удаагийн яриа хэлэлцээ өрнүүлж, Харилцан ойлголцлын хоёр санамж бичиг байгуулсны үр дүнд энэхүү гэрээг 2023 оны тавдугаар сард үзэглэсэн юм. Энэхүү нэмэлт гэрээ нь Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээний хугацааг 2030 он хүртэл сунгаж буй бөгөөд гэрээг цуцлах эрх 2028 оны 7 дугаар дугаар сард Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-д үүсэх юм.

Ил хуваарилах байгууламж

Цахилгаан хэрэглээний өсөлт Монгол Улсын эрчим хүчний салбарт тулгамдсан асуудал болоод буй. Улмаар сүүлийн жилүүдэд хүйтний улирлын оргил ачааллын үед цахилгаан хязгаарлалт 3.3 хувьд хүрээд байна. Өнгөрсөн хугацаанд ОХУ-аас импортлох замаар цахилгааны алдагдлыг нөхөж ирсэн боловч 2022 оны хүйтний улиралд 340МгВ буюу дээд хязгаартаа хүрсэн.

Цахилгаан эрчим хүчний хэрэглээ жилд 6-8 хувиар өсөж байгаа нь Монгол Улсын тулгамдсан асуудал болж, цахилгааны тасалдлаас сэргийлэх чиглэлд яаралтай арга хэмжээ авах шаардлага үүссэн. Оюу толгойн уурхайг эрчим хүчээр хангах зориулалттай цахилгаан дамжуулах шугамыг ашиглан БНХАУ-аас нэмэлт цахилгаан эрчим хүч импортлоход хамтран ажиллах саналыг Эрчим хүчний яамнаас "Оюу толгой" ХХК-д тавьсан билээ. Хамтран ажиллах энэхүү хүсэлтийг "Оюу толгой" ХХК нааштай хүлээн авч уурхайн цогцолборын талбайд цахилгаан ил

хуваарилах байгууламжийн санхүүжилт болон барилга угсралтын ажилд оройлон оролцож байна. Энэ нь Оюу толгойд нийлүүлэгдэх цахилгаан эрчим хүчний аюулгүй болон найдвартай байдлыг алдагдуулалгүйгээр Монгол Улсын цахилгаан эрчим хүчний шугамд нэмэлт цахилгаан нийлүүлэх ажлыг хялбарчлах ач холбогдолтой. 2025 оны эхээр хэрэгжиж дуусах уг төсөл одоогоор худалдан авалтын шатандаа явна.

“Сэргээгдэх эрчим хүчний шийдэл”-ийн төсөл

“Оюу толгой” ХХК Монгол Улсын Засгийн газартай байгуулсан “Цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ”-ний дагуу хэрэглээнийхээ оргил үед ашиглах 1,300 гигаватт/цаг (ойролцоогоор 70 хувь) цахилгааныг төвийн шугамаас авна. Харин

хэрэглээнийхээ үлдсэн 30 орчим хувь болох ойролцоогоор 600 гигаватт/цаг цахилгааныг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр шийдвэрлэхийг “Рио Тинто”-той хамтран эрэлхийлж байна.

Оюу толгойн уурхай байрлах өмнийн говийн бүс нутаг нь салхи болон нарны эрчим хүчний нөөц сайтайгаас гадна байгаль, газар зүйн тогтоцын хувьд тохиромжтой учир сэргээгдэх эрчим хүчний төсөл хэрэгжүүлэхэд нэн таатай нутаг юм. “Рио Тинто” компани энэхүү санаачилгад идэвхтэй оролцож буй бөгөөд төслийн хамтрагчийг сонгон шалгаруулах ажил ид явагдаж байна.



ТУЗ ба Хувьцаа эзэмшигчдийн хурал

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Хувьцаа эзэмшигчдийн 21-р хурал – 2023 оны 4-р сарын 20 (жил тутмын ерөнхий хурал)

Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал

52-р хурал – 2023 оны 3-р сарын 16

53-р хурал – 2023 оны 6-р сарын 7-8

54-р хурал – 2023 оны 9-р сарын 20

55-р хурал – 2023 оны 11-р сарын 23-нд хуралдаж, 12-р сарын 11, 13-нд үргэлжилсэн

Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурал

Ээлжит бус 46-р хурал – 2023 оны 5-р сарын 31

Ээлжит бус 47-р хурал – 2023 оны 6-р сарын 21

Аудит, санхүүгийн хороо (АСХ)-ны хурал

Аудит, санхүүгийн хорооны 54-р хурал – 2023 оны 3-р сарын 15

Аудит, санхүүгийн хорооны 55-р хурал – 2023 оны 6-р сарын 6

Аудит, санхүүгийн хорооны 56-р хурал – 2023 оны 9-р сарын 19

Аудит, санхүүгийн хорооны 57-р хурал – 2023 оны 11-р сарын 21, 22

Үйл ажиллагааны хороо (ҮАХ)-ны хурал

Үйл ажиллагааны хорооны 50-р хурал – 2023 оны 3-р сарын 15

Үйл ажиллагааны хорооны 51-р хурал – 2023 оны 6-р сарын 6-7

Үйл ажиллагааны хорооны 52-р хурал – 2023 оны 9-р сарын 19

Үйл ажиллагааны хорооны 53-р хурал – 2023 оны 11-р сарын 22

Хүний нөөц, сургалтын хороо (ХНСХ)-ны хурал

Хүний нөөц, сургалтын хорооны 50-р хурал – 2023 оны 3-р сарын 15

Хүний нөөц, сургалтын хорооны 51-р хурал – 2023 оны 6-р сарын 6

Хүний нөөц, сургалтын хорооны 52-р хурал – 2023 оны 9-р сарын 19

Хүний нөөц, сургалтын хорооны 53-р хурал – 2023 оны 11-р сарын 21

Хамтын ажиллагааны хороо (ХАХ)-ны хурал

Хамтын ажиллагааны хорооны 23-р хурал – 2023 оны 3-р сарын 15

Хамтын ажиллагааны хорооны 24-р хурал – 2023 оны 6-р сарын 6

Хамтын ажиллагааны хорооны 25-р хурал – 2023 оны 9-р сарын 19

Хамтын ажиллагааны хорооны 26-р хурал – 2023 оны 11-р сарын 22

ТУЗ-ийн бүрэлдэхүүн (2023)

Галсангийн Батсүх

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга,
Оюу Толгой ХХК

Дэйдрэ Лингенфэлдер

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн,
Оюу Толгой ХХК

Элиас Скафидас

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн,
Оюу Толгой ХХК

Сүхбаатарын Мөнхсүх

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн,
Оюу Толгой ХХК

Стив Тибоу

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн,
Оюу Толгой ХХК

Крейг Стэгман

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн,
Оюу Толгой ХХК

Намсрайн Цэрэнбат

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн,
Оюу Толгой ХХК

Энхбаатарын Баясгалан

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн,
Оюу Толгой ХХК

Жамбалдоржийн Тана

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн,
Оюу Толгой ХХК
/2023 оны 4-р сараас/

Нацагийн Багабанди

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн асан,
Оюу Толгой ХХК
/2023 оны 4-р сар хүртэл/





Зургийг М.Ганзориг
"Боловсрол" телевизийн "Гэрэл зургийн мастер" реалити шоуны ялагч

